



# Монголын Төрийн бус байгууллагууд



**Гарын авлага**

**ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газар**

**2022 он**

## Өмнөх үг

ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газар нь Монгол улсад техникийн хамтын ажиллагаа, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, сайн дурын гишүүн илгээх зэрэг олон тооны төсөл хөтөлбөрийг төрөл бүрийн салбарт хэрэгжүүлж ирсэн.

2021 оны 10 сард Япон, Монголын төрийн бус байгууллага болон ЖАЙКА хоорондын харилцаа холбоог гүнзгийрүүлэх зорилгоор төрийн бус байгууллага хариуцсан нэгжийг төлөөлөгчийн газар дотроо шинээр байгуулсан. Тус нэгж байгуулагдсанаасаа хойш Монголд үйл ажиллагаа явуулах хүсэлтэй Японы төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүст Монголын төрийн бус байгууллагуудын талаар мэдээлэл өгч, танилцуулах зорилгоор Монгол улсын төрийн бус байгууллагуудын мэдээллийг цуглуулж, орчуулан Япон хэл дээр гарын авлага болгон гаргасан билээ.

Гарын авлагыг боловсруулахаар мэдээлэл цуглуулах явцад Монгол улсад бүртгэлтэй төрийн бус байгууллага 25,000 гаруй байдаг ба үүнээс ихэнх нь тогтвортой, идэвхитэй үйл ажиллагаа явуулдаггүй, ямар салбар чиглэлээр ажилладаг нь ойлгомжгүй зэрэг асуудлууд байсан тул энэ удаад тус гарын авлагыг шинэчлэн Монгол хэл дээр хэвлэн гаргах шаардлага зүй ёсоор бий гэж үзсэн болно.

Уг гарын авлагад 93 төрийн бус байгууллагын мэдээллийг үйл ажиллагааны чиглэл бүрээр ангилан нэгтгэхийг хичээлээ. Энэ дашрамд, бидэнд мэдээллээ ирүүлж, хамтран ажилласан төрийн бус байгууллагын холбогдох хүмүүст талархал илэрхийлье.

Гарын авлагад орсон мэдээллийг ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газар бие даан цуглуулсан бөгөөд Монгол улсын нийт төрийн бус байгууллагын мэдээлэл багтаагүй гэдгийг, мөн гарын авлагад орсон төрийн бус байгууллагыг ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын зүгээс тулган санал болгож буй хэрэг огт биш гэдгийг ойлгоно гэдэгт найдаж байна.

Эцэст нь, 2022 он бол Япон, Монгол хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жил, ЖАЙКА-гийн Сайн дурын гишүүн Монголд илгээсний 30 жил, ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газар байгуулагдсаны 25 жилийн ой тус тус тохиож буй тэмдэглэлт ойн жил юм. Та бүхэнд энэ түүхэн ойн жилийн мэндийг хүргэхийн сацуу хоёр орны харилцаа улам цэцэглэн хөгжихийн ерөөл өргөө.

ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газар

2022 он

## Агуулга

	Үйл ажиллагааны чиглэл	ТББ-ын нэр	Хуудас
1	Хөгжлийн бэрхшээл	Түгээмэл хөгжил төв /Universal Progress/	6
2		Монгол улсын Сонсголгүй иргэдийн үндэсний холбоо	8
3		Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо	10
4		Монголын Аутизмын холбоо	12
5		Монголын Дауны холбоо	14
6		Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо	16
7		Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо	18
8		Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо	20
9		Энэрэлийн түүчээ	22
10		Ээлтэй ертөнц	24
11		Бид чадна эм эн нэгдэл	26
12		Сайн найз төв	28
13		Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо	30
14		DET форум	32
15		Батэгшиглэн ТББ	34
16		Хан-Уул бие даан амьдрах төв	35
17		Монголын харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын холбоо	36
18		Салхич шувуу	38
19		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо	40
20	Хүүхэд, эмэгтэйчүүд хамгаалал	Лантуун дохио	42
21		Хөөрхөн зүрх /Beautiful Hearts/	44
22		Хүүхдийг ивээх сан	46
23		Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	48
24		Нар Сар Оюу	49
25		Бор тагшны бодол	50
26		Ирээдүйн нээлттэй цонх	52
27		Эмэгтэй удирдагч сан	54

28		Өсвөр үеийнхний хөгжлийн төв	56
29		Эмэгтэйчүүд хүүхэд хөгжил төв	58
30		Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо	59
31		Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	60
32		Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо	62
33		Манай гэр нийгэмлэг ТББ “Миний гэр” хүүхдийн асрамжийн газар	64
34		Монголын СОС хүүхдийн хотхон	66
35		Хөгжлийн хэлхээ	68
36		Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төв	70
37		Монголын эмэгтэйчүүдийн сан	72
38		Нийгмийн түншлэлийн сүлжээ	74
39		Монголын эмэгтэйчүүд амьдрал төв	76
40		Бадамлянхуа хүүхдийн төв	78
41		Сайн ирээдүйн төлөө	79
42		Монголын хүүхдийн эрхийн үндэсний төв	80
43		Дэлхийн Зөн Монгол ОУБ /World Vision Mongolia/	82
44		Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах “ГҮНЖ” төв	84
45	Боловсрол	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	86
46		Хайр эрдэм билиг	88
47		Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг	90
48		Иргэний боловсролын төв	92
49		Сайн боловсролын төлөө	94
50		Бүх нийт боловсролын төлөө	95
51		Уншигч хөтөлбөр /Reader NGO/	96
52		Боловсролын реформ хөдөлгөөн /Education Reform NGO/	98
53		Монжи-Шанд	100
54	Бүс нутгийн хөгжил	Толгойт хорооллын нутгийн хөгжил төв	102
55		Шинэлэг түлхүүр хөгжил соёлын төв	104
56		Ноосон эдлэлийн гар урлалыг дэмжих төв	106
57		Шинэ замнал	108
58		Сэрсэн талын салхи	110
59	Байгаль орчин	Монголын байгаль орчны иргэний зөвлөл	111
60		Монголын байгаль орчныг хамгаалах холбоо	112
61		Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн дэвшлийн төв	114



62		Байгаль орчин, эрүүл мэнд төв	116
63		Ирээдүйн хөгжлийн хүрээлэн	118
64		Байгаль орчны мэдээлэл сургалтын төв	120
65		Хомын талын тахь	122
66	Мансууруулах бодис, согтууруулах ундаанаас урьдчилан сэргийлэх	Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг	124
67		Санрайз халфвэй хаус халамж үйлчилгээний төв	126
68	Хөдөө аж ахуй	Монголын зөгийчдийн нийгэмлэг	128
69		Монголын хөдөө аж ахуйн дэвшил холбоо	130
70		Монголын жимс жимсгэний үндэсний холбоо	132
71		Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо	134
72		Монгол Ви.И.Ти.НЕТ /Mongolia V.E.T Net NGO/	135
73	Хүний эрх	Хүний эрх хөгжил төв	136
74		Хүйсийн тэгш эрх төв	137
75		Түгээмэл эрх хөгжил	138
76	Сайн дурын үйл ажиллагаа	Сайн дурынхны хөгжлийн төв	140
77	Эрүүл мэнд	Монголын неврологийн нийгэмлэг	141
78		Сэтгэл судлалын үндэсний төв	142
79		Увидас сэтгэл зүйн төв	144
80		Ивээл цогц хөгжил төв	146
81		Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг	148
82		Монголын радиологийн нийгэмлэг	150
83		Хоол зүй, шим судлалын Монголын нийгэмлэг	152
84		Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоо	154
85		Монголын мэдээгүйжүүлэгч эмч нарын нийгэмлэг	156
86		Орбис Олон улсын байгууллагын Монгол дахь салбар төлөөлөгчийн газар	157
87		Монголын сувилагчдын нийгэмлэг	158
88		Монголын эх баригчдын холбоо	160
89		Солонгон хүүхдүүд	162
90		Элэгсэг оршихуй	164

91		Монголын мэргэжилтэн хоорондын хамтын ажиллагааны нийгэмлэг	165
92		Ачлалт хүүхдүүд	166
93		Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн	168

### **ЖАЙКА-гийн Монгол дахь Төлөөлөгчийн газар**

Хаяг : УБ, СБД, 3-р хороо, Бодь цамхаг, 7 давхар

Шуудангийн хаяг : Central P.O.Box682, Ulaanbaatar 15160, Mongolia

Холбоо барих : 976-11-312393, 311329

FAX : 976-11-310845

Й-Мэйл : [jicamg\\_ngodesk@jica.go.jp](mailto:jicamg_ngodesk@jica.go.jp), [mg\\_oso\\_rep@jica.go.jp](mailto:mg_oso_rep@jica.go.jp)

Вэб:[www.jica.go.jp/Mongolia/index.html](http://www.jica.go.jp/Mongolia/index.html)

FB: JICA Mongolia

YouTube:JICA Mongolia-YouTube

**Түгээмэл Хөгжил төв**

Байгууллагын нэр	Түгээмэл Хөгжил төв
Үүсгэн байгуулагдсан он	2010 он
Хаяг	Баянгол дүүрэг, 2-р хороо, цагдаагийн 58-р байр, 0 тоот
Утасны дугаар	76015800, 88953883
E-mail	Info.upmilc@gmail.com
URL/Facebook	Түгээмэл Хөгжил /"Universal Progress" MILC/
Төлөөлөгчийн нэр	Я.Авирмэд Н.Мөнхжаргал
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Түгээмэл Хөгжил төв нь 2010 онд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үүсгэл санаачилгаар байгуулагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний бие даан амьдрахад дэмжих үйлчилгээ үзүүлдэг гишүүддээ болон нийгэмд чиглэсэн хүний эрхийг хамгаалахын төлөө үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллага юм.</p> <p>Түгээмэл Хөгжил төв үүсэн байгуулагдсан цагаасаа нийтийн тээвэр, барилга байгууламжийн хүртээмжийн асуудлыг голлон авч үзэн түүнд хамаарах нийгмийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, төрийн бодлого үйл ажиллагаанд тусгуулах чиглэлд тасралтгүй ажиллаж байна.</p> <p>Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, чадвахижуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн ойлголт хандлагыг өөрчлөх зорилгоор тодорхой төлөвлөгөөтэй үйл ажиллагаа хэрэгжүүлдэг. Үндсэн 17 ажилтантай үүний 12 хөгжлийн бэрхшээлтэй, 5 хөгжлийн бэрхшээлгүй, 30 гаруй цагийн ажилчидтай. 160 орчим гишүүнтэй Монголын Бие Даан амьдрах төвүүдийн үндэсний холбооны гишүүн байгууллага.</p> <p>Дараах 3 чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. <u>Бие даан амьдрахад дэмжих хөтөлбөр</u> <ul style="list-style-type: none"> <li>- Хувийн туслах үйлчилгээ</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зөвлөлдөөн, ярилцлага /peer counseling/</li> <li>- Бие даан амьдрах хөтөлбөр</li> </ul> </li> <li>2. <u>Нийгмийн оролцоог дэмжих хөтөлбөр</u> <ul style="list-style-type: none"> <li>- Нөлөөллийн ажил (Адвокаси)</li> <li>- Хөдөлмөр эрхлэлт</li> <li>- Судалгаа, мониторинг</li> <li>- Гишүүдийн хөгжил</li> <li>- Хүртээмжийн зөвлөгөө,</li> </ul> <p>Сургалтын дараах 3 төрөлд хуваадаг</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Гишүүдэд чиглэсэн сургалт:</li> <li>➢ Байгууллагуудад чиглэсэн сургалт:</li> <li>➢ Хувийн туслах ажилчдад чиглэсэн сургалт</li> </ul> </li> <li>3. <u>Боловсролын хөтөлбөр</u> <ul style="list-style-type: none"> <li>- Тэгш хамруулан сургах бодлогыг дэмжих</li> <li>- Сургалт зохион байгуулах</li> <li>- Зөвлөгөө өгөх</li> </ul> </li> </ol>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Азийн болон Дэлхийн бие даан амьдрах төвүүдийн нэгдсэн сүлжээний гишүүн байгууллага. Азийн 8 орон хамтарсан Кокорозаши сүлжээний гишүүн
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	JICA DPUB ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төслийн хүрээнд Түгээмэл хөгжил төвийн ажилчид гишүүдээс нийт 10 хөгжлийн бэрхшээлтэй иргэн сургалт хөтөлбөрүүд нь хамрагдаж Япон улс руу туршлага солилцох хөтөлбөрт хамрагдаж явсан.



Сургалт мэдээлэл



Гишүүдийн уулзалт



Mongolia TRY нөлөөллийн ажил



## Монгол Улсын Сонсголгүй Иргэдийн Үндэсний Холбоо

Байгууллагын нэр	Монгол Улсын Сонсголгүй Иргэдийн Үндэсний Холбоо ТББ
Үүсгэн байгуулагдсан он	1978 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, Цагдаагийн гудамж, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, II байр
Утасны дугаар	94050530
E-mail	deaf.mongolia@gmail.com
URL/Facebook	<a href="https://www.facebook.com/mgldeaf">https://www.facebook.com/mgldeaf</a>
Төлөөлөгчийн нэр	А.Энхбаатар, Ерөнхийлөгч
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монгол Улсын Сонсголгүй Иргэдийн Үндэсний Холбоо (МУСИҮХ) нь анх 1978 оны 5-р сарын 25-нд тухайн үеийн БНМАУ-н Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Монголын хараагүй, хэлгүй, дүлий иргэдийн аж амьдралыг тууштай дээшлүүлэх, тэдний материаллаг болон оюуны хэрэгцээг дүүрэн хангах талаар зорилготойгоор 10.000 гишүүнтэй байгуулагдаж байсан түүхтэй.</p> <p>1994 онд нийгэм эдийн засгийн өөрчлөлтөөс улбаалан “Монгол Улсын Сонсголгүй Иргэдийн Үндэсний Холбоо” (МУСИҮХ) ТББ болон өнөөг хүртэл бие даасан үйл ажиллагаагаа явуулж ирлээ.</p> <p>Монгол Улсын Сонсголгүй Иргэдийн Үндэсний Холбоо (МУСИҮХ) нь 1979 онд Дэлхийн Дүлий Иргэдийн Холбоо (World Federation of the Deaf)-ын жинхэнэ байнгын гишүүнээр элссэн бөгөөд Монголын сонсголгүй иргэдийг тус холбоонд төлөөлөх бүрэн эрхт цорын ганц ууган байгууллага юм. Мөн 1992 онд Ази Тивийн Сонсголгүй Иргэдийн Холбоо (World Federation of the Deaf Regional Secretariat Asia)-нд гишүүнээр элссэн.</p> <p><b>ЭРХЭМ ЗОРИЛГО:</b></p> <p>Үндэсний холбоо нь Монгол улсад амьдарч буй нийт сонсголгүй болон сул сонсголтой иргэдийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэднийг бүх талаар дэмжин туслах, дохионы хэл, эрүүл мэнд, боловсролын тусламж үйлчилгээ, үйл ажиллагааг хүрээмжтэй чанартай үр дүнтэй төлөвлөн зохион байгуулж хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.</p> <p><b>АЛСЫН ХАРАА:</b></p> <p>Монгол улсын сонсголгүй болон сул сонсголтой иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоо хэрэгжүүлэхдээ Ази тивийн болон Дэлхийн холбоо, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана. Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээний дагуу Монгол улсын сонсголгүй иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг тууштай хамгаалж, тэднийг нийгмийн бүхий л харилцаанд эрх тэгш иргэн байх явдлыг хангана.</p> <p>Монгол Улсын Сонсголгүй Иргэдийн Үндэсний Холбоо нь иргэдийнхээ эрхийг хамгаалах, сонсголгүй иргэдийн хөгжил, эрүүл мэнд, боловсрол, соёл, спортын үйл ажиллагааг чанартай хүртээмжтэй явуулахаас гадна төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үйл ажиллагаагаа бэхжүүлэх зорилго тавин ажилласаар ирсэн.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Японы Сонсголгүй Иргэдийн Холбоо, Nippon Foundation, The Japan Foundation Олон Улсын хамтын Байгууллагатай мэдээлэл солилцох, соёлын харилцаа, эдийн засгийг дэмжин хамтран ажиллахыг хүсэж байна.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	JICA DPUB Монгол Улс дахь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төслийн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.





## Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо

Байгууллагын нэр	Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо НҮТББ
Үүсгэн байгуулагдсан он	2011 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 10-р хороо, Их Тойруу гудамж ,44-р байр, 1-р орц 2 давхарт 6 тоот
Утасны дугаар	70001220, 99624411
E-mail	Masli.mongolia@gmail.com
URL/Facebook	www.masli.mn, <a href="https://www.facebook.com/MASLI.MN">https://www.facebook.com/MASLI.MN</a>
Төлөөлөгчийн нэр	Тэргүүн Л.Соёлмаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>“Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо” (ДХХОХ) нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага нь сонсголгүй иргэд нийгэмд эрх тэгш оролцох, бие даан амьдрах, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, болон бусадтай харилцахад хэлмэрч орчуулагчийн үйлчилгээг үзүүлэх зорилготойгоор 2011 онд байгуулагдсан (РД: 8050457). Тус байгууллага нь тухайн үеийн Хүн Амын Хөгжил Нийгэм Хамгааллын Яамны Батламжтай (2014.12.03) ба 2013 онд Дэлхийн дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбооны “Үндэсний гишүүн” байгууллагаар элсэн орсон.</p> <p>ДХХОХ ТББ нь Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам, Цагдаагийн Ерөнхий газар зэрэг төрийн болон төрийн бус 40 гаруй байгууллагуудтай дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээ үзүүлэх гэрээтэй ажилладаг. Мөн ДХХОХ ТББ нь Сонсголгүй иргэдийн иргэний нийгмийн байгууллагууд, бусад Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг.</p> <p>ДХХОХ ТББ –ийн гишүүн орчуулагчид мэргэжлийн ба гишүүн орчуулагч, дадлагажигч орчуулагч гэсэн шатлалаар хэлмэрчдийг дадлагажуулж сургадаг бөгөөд удирдах зөвлөлд сонсголгүй иргэдийн төлөөлөлтэй. Хэлмэрч орчуулагчид “Дохионы хэлний хэлмэрч орчуулагчийн ёс зүйн дүрэм”-ийг баримталж ажилладаг.</p> <p>ДХХОХ нь 2013 оноос дохионы хэлний хэлмэрч орчуулагчдыг Сонсголгүйн Боловсрол ТББ-тай хамтран бэлтгэж байна. Одоо ДХХОХ нь 11 гишүүн хэлмэрч орчуулагч, 7 суралцагч гишүүн хэлмэрч, 4 сонсголгүй дохионы хэлмэрчид үндсэн болон гэрээлэн ажилладаг.</p> <p>2020 онд ДХХОХ нь сонсголгүй иргэдэд зайн дүрс ярианы үйлчилгээг нэвтрүүлж Дохионы хэлний видео дуудлага Фейсбүүк хаягаар онлайн хэлмэрчийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн бөгөөд 2021 оноос эхлэн ХНХЯ-тай хамтран онлайн хэлмэрчийн үйлчилгээг <a href="http://www.duudlaga.mn">www.duudlaga.mn</a> хаягаар олон нийтэд хүргэж байна. (Зураг 1)</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Дэлхий дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбооны Үндэсний гишүүн бөгөөд монгол улсаас төлөөлдөг Дохионы хэлний хэлмэрчийн байгууллага юм. Тус холбооны Япон болон Азийн гишүүн байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд Солонгосын Дохионы хэлний хэлмэрчдийн холбоотой хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хамтран ажилладаг.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	2021 оноос ЖАЙКА-тай хамтран анх удаа Сонсголгүй хүүхдийг ЕСБ-д дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээтэй тэгш хамран сургах төслийг хэрэгжүүлж байна. Тус холбоо нь өмнө нь сонсголгүй хүүхдийн боловсролд хос соёлын арга зүйн төслүүдийг 2-5 жилийн хугацаанд Сонсголгүйн боловсрол ТББ-тай хамтдаа амжилтай хэрэгжүүлсэн. Энэхүү төслүүдийн үр дүнгийн үргэлжлэл болох 2 сонсголын бэрхшээлтэй сурагчийг 29-р сургуулийн бага ангиа хос хэлний арга зүйгээр суралцсаны дараа 6-р ангиасаа нь ЕБ-ын 16-р сургуульд эцэг эхийн хүсэлтээр, сургуулийн удирдлагын зөвшөөртэй шилжүүлсэн сургасан. Ингэхдээ ДХХОХ ТББ-с дохионы хэлний хэлмэрчийн үйлчилгээ үзүүлж бүх хичээл дохионы хэлний орчуулагчтай явж байна. <p>Сонсголгүй хүүхэд эрт оролцооны хөтөлбөр, СӨБ, бага боловсролоо хос хэлээр Дохионы хэл, бичгийн хэл эзэмшээд дунд ангиасаа ЕБС-д тохируулга үйлчилгээ хэлмэрчтэй суралцах боломжийг туршин энэхүү төслийг хэрэгжүүлснээр цаашид "Сонсголгүй хүүхдийг тэгш хамран сургах тогтолцоонд туслах багш-хэлмэрчийн орон тоо, ажлын байрны хэрэгцээг тодорхойлж, тогтолцоонд тусгах зорилготой юм.</p>









## Монголын Аутизмын холбоо

Байгууллагын нэр	Монголын Аутизмын Холбоо
Үүсгэн байгуулагдсан он	2014 он
Хаяг	Баянгол дүүрэг, 3-р хороо, Дундголын гудамж, Цагдаа 2 хотхон, 30А байр, 32 тоот
Утасны дугаар	91859191
E-mail	autismassociationmongolia@gmail.com
URL/Facebook	Autism Association of Mongolia
Төлөөлөгчийн нэр	Ш.Байгалмаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монголын Аутизмын Холбоо нь аутизмтай хүүхэдтэй монгол эцэг эхчүүдийн санаачлагаар байгуулагдан, сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг НҮТББ юм.</p> <p>Бид эцэг эхчүүдээ чадавхжуулахын тулд монгол хэлээр ном, эх сурвалж бэлтгэн гаргах, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах; гадаад дотоодын төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах; нийгэмд аутизмын тухай зөв, эерэг ойлголтыг түгээх чиглэлээр ажилладаг.</p> <p>Бид тусгай хэрэгцээт боловсролд хамрагдаж байгаа аутизмтай хүүхдүүдийн боловсролын хүртээмжийг сайжруулах үүднээс Улаанбаатар хотын ба орон нутгийн тусгай сургуулийн сурагчдад зориулж тайвшруулах өрөө, анги танхим байгуулж, багш нарт сургалт хийж, ном, гарын авлага, хэрэглэгдэхүүнээр хангасан билээ.</p> <p>Мөн аутизмтай хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургах боломжийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч, “Аутизмын Хүрээний Эмгэгтэй сурагчдыг боловсролд тэгш хамруулах нь” багш нарт зориулсан гарын авлагыг боловсруулж, хэвлүүлэн Монголынхоо бүх багш нарт түгээн туршуулж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• АНУ-ын Фулбрайт хөтөлбөрийн мэргэжилтэн багш урьж тэгш хамруулах боловсролын тухай сургалт явуулсан</li> <li>• АНУ-ын Иллиноисын Их сургуулийн Зан үйлийн шинжээч багшийг урьж эцэг эхчүүдэд сургалт зөвлөгөө өгүүлсэн</li> <li>• Канад сангийн тэтгэлгээр хөдөө орон нутагт тусгай бүлгийн сурагчдад зориулсан төсөл хэрэгжүүлсэн</li> <li>• Австралийн ЗГ-ын дэмжлэгээр Улаанбаатар хотын тусгай сургуульд аутизмтай сурагчдад ээлтэй сурах орчин байгуулах төсөл хэрэгжүүлсэн</li> <li>• Zonta ОУБ-ын дэмжлэгээр ээжүүдэд сургалтууд зохион байгуулж, аутизмтай хүүхдүүдийг сургах хэрэглэгдэхүүн хэвлүүлсэн</li> <li>• Японы Sport for Tomorrow байгууллагын дэмжлэгтэйгээр Монголын Тусгай Олимпийн ширээний теннисний багийг ширээ, хувцас, хэрэглэгдэхүүнээр хангаж, тэмцээнүүд зохион байгуулсан</li> <li>• Япон аутизмтай хүү Хигашида Наокийн “Би яагаад үсэрдэг вэ?” номыг албан ёсны эрхтэйгээр орчуулж хэвлүүлсэн</li> </ul>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>• JICA байгууллагын START төсөлтэй хамтран ажиллаж тус төслийн мэргэжилтэн зөвлөх багш нараас сургалт зөвлөгөөг авч байсан</li> <li>• JICA START төсөлтэй “Аутизмтай хүүхэдтэй эцэг эхчүүдийн асуудаг түгээмэл асуултууд” номыг хамтран гаргасан</li> <li>• JICA START төсөлтэй “Аутизмын Хүрээний Эмгэг” видео хичээлийг бэлтгэн гаргахад хамтран ажилласан</li> <li>• JICA START төсөлтэй Хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг арилгах эрт үеийн оролцооны “Портэж” хөтөлбөрийг Монгол улсад нутагшуулан нэвтрүүлэхэд түншлэн ажилласан</li> <li>• JICA Mongolia байгууллагын санхүүжилтээр бүх сум, хороодын мэргэжилтнүүдэд “Аутизмын тухай гарын авлага”-г хүргүүлсэн</li> <li>• JICA Mongolia байгууллагын санхүүжилтээр алслагдсан 5 аймгийн гэр бүлүүдэд судалгаа хийж, зөвлөгөө өгсөн</li> <li>• JICA Mongolia байгууллагын санхүүжилтээр “Аутизмын тухай” цуврал видео хичээлүүдийг бэлтгэн гаргасан.</li> </ul>



Autism Association of Mongolia



БАГШ, ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОРИУЛСАН  
АУТИЗМЫН ТУХАЙ  
ГАРЫН АВЛАГА



## Монголын Дауны холбоо

Байгууллагын нэр	Монголын Дауны Холбоо
Үүсгэн байгуулагдсан он	2007он
Хаяг	Хүүхэд хөгжлийн төв Хаяг: Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Хурд хорооллын Рапид харш, Махатма Гандийн гудамж, 28-р байрны 1 тоот Утас: 76024321 Хөдөлмөр сургалтын төв болон оффис Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайвны өргөн чөлөө 17, Зориг сангийн хашаанд Утас: 70009688
Утасны дугаар	70009688, 99116663, 99844884
E-mail	321dsamongolia@gmail.com
URL/Facebook	DSAMmn
Төлөөлөгчийн нэр	Холбооны тэргүүн В.Ганзориг, Гүйцэтгэх захирал Б.Наранжаргал
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монголын Дауны Холбоо нь эх эцгүүдийн санаачлагаар 2007 онд байгуулагдсан ашгийн бус, төрийн бус байгууллага бөгөөд эдүгээ нийслэл болон хөдөө орон нутгийн 600 гаруй гишүүдийг эгнээндээ нэгтгээд байна. Холбооны гол зорилгын нэг нь оюуны бэрхшээлийн нэг төрөл болох дауны хам шинж буюу хромосомын өөрчлөлттэй хүүхэд, түүний гэр бүлийн эрхийг хамгаалах, хөгжлийн дэмжлэг үзүүлэх, нийгэмших боломжийг бүрдүүлэхийн тулд бүх түвшний оролцогч талуудыг нэгдсэн ойлголтод хүргэх явдал юм.</p> <p>Бидний эрхэм зорилго: Дауны хам шинжтэй хүнийг хөгжүүлэх, эрхийг нь хамгаалах, нийгэмд эерэгээр таниулахад туслах.</p> <p>Алсын хараа: Дауны хам шинжтэй иргэнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцдог Монгол улсын татвар төлөгч болгон төлөвшүүлэх</p> <p>Бид байгуулагдсан цагаасаа эхлэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Ази, Номхон Далайн Дауны Холбооны албан ёсны гишүүн төдийгүй энэхүү олон улсын нэр хүндтэй байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөлд саналын эрхтэй сонгогдон ажиллаж байна. Бид Дэлхийн дауны холбооны гишүүн бөгөөд НҮБ-ын Нью Йорк болон Женевийн төв оффист Дэлхийн дауны өдрөөр уригдан илтгэл тавьж байсан бөгөөд олон улсад идэвхтэй ажилладаг. Холбооноос дауны хам шинж гэж юу болох, түүний онцлог, эрт илрүүлэг, хөгжлийн түвшний тодорхойлолт, боловсрол, сэтгэлзүйн талаар манай улсад нэн дутагдалтай байгаа мэдлэгийг эх эцгүүд болон нийгэмд олгох, даунтай хүүхэдтэй ажиллах арга зүйгээр хангах, нийгэмд эерэг хандлага, үйл ажиллагаа, зөв ойлголтыг бүрдүүлэх зорилгоор сүүлийн 10 гаруй жилийн турш дотооддоо болон олон улсад төрөл бүрийн контент ажиллаж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Дэлхийн Дауны Холбоо, Ази Номхон далайн дауны холбоо, Польшийн ЭСЯ, Азийн сан, ЖАЙКА
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	<p>Холбооны тэргүүн В.Ганзориг, гүйцэтгэх захирал асан Б.Батцэцэг нар ЖАЙКА-гийн сургалтанд хамрагдан Япон, Камбож, Тайланд улсуудын тэргүүн туршлагыг Монголдоо нэвтрүүлэх, сургалтын явцад олж авсан мэдлэг, туршлагыг эх орондоо хэрэгжүүлэх чин зорилготой ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд Монголын Дауны Холбооноос эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага, Мэргэжилтнүүдийн зөвлөгөө бүхий товхимолыг хэвлэсэн бөгөөд Япон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-ын Монгол дахь Төлөөлөгчийн газар болон ЖАЙКА-ийн шугамаар Японд сургалт төгсөгчдийн холбоо ивээн тэтгэж, Монгол орны өнцөг булан бүрт тараах ажлыг дэмжсэнд гүн талархал илэрхийлж байна. Энэ ном эцэг, эхчүүд төдийгүй багш, эмч, нийгмийн ажилтан, сайн дурынханы ширээний ном болсон гэдэгт эргэлзэхгүй байна.</p> <p>Түүнчлэн ковидын хатуу хөл хорионы хүнд үед эцэг эхчүүд, багш, эмч, нийгмийн ажилтан, сайн дурынхан, хэвлэл мэдээллийн салбарынханд зориулсан цуврал видео хичээлийг бэлтгэн онлайнаар холбооныхоо бүх гишүүд болон олон нийтэд хүргэн түгээх ажлыг амжилттай хийлээ.</p> <p>2021 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан дауны хам шинжийн тухай зөв мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээх, ЖАЙКА-тай хамтран ажиллаж буй төслүүдээ олон нийтэд хүргэх ажил дээр хамтран ажиллаж цахим сайтад ярилцлага өгөх ажлыг хамтдаа хийсэн.</p>





**Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо**

Байгууллагын нэр	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо
Үүсгэн байгуулагдсан он	1999 он
Хаяг	Баянгол дүүрэг, 2-р хороо, 26-р байр
Утасны дугаар	99152896,89152896,70052530
E-mail	Enkhee_0910@yahoo.com
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	Лувсандамба Энхбаяр
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо нь / МХБИЧҮЭХ / хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон нийтлэг эрх ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалж энэ чиглэлээр бие даасан үйл ажиллагаа явуулдаг төрийн бус олон нийтийн байгууллага билээ.</p> <p>Тус холбоо нь 1999 оны 12-р сарын 03-ны өдөр байгуулагдсан бөгөөд, Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймагт ҮЭ-ийн зөвлөлийн үндсэн салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа үндэсний хэмжээнд тогтвортой явуулж байна.</p> <p>Манай ҮЭХ-ны үндсэн нэгж салбаруудын дарга нарын 68% нь эмэгтэйчүүд, 32% нь эрэгтэй дарга нар удирддаг бөгөөд 2020 оны эцсийн байдлаар ҮЭ-ийн албан ёсны бүртгэлтэй 18.618 гишүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаагаас гадна, ҮЭХ-ныхоо дэргэд ХБИ бичил бизнесийн хөгжлийг дэмжих төв, Алсын зайн явуулын сургалт мэдээллийн төвүүдээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулж, гишүүд дэмжигчдээ чадавхжуулах, мэргэжлийн ур чадвар олгох болон тэдгээр иргэдийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр 22 дахь жилдээ амжилттай үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангах, хамгаалах талаар олон талт ажлыг зохион байгуулж ирсэн бөгөөд, НҮБ-аас батлан гаргасан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцийг Монгол Улсад батлуулахад голлох үүрэг гүйцэтгэсэн бөгөөд, Ази Номхон далайн бүсийн орнуудын Засгийн газрын удирдлагуудын дээд хэмжээний уулзалтаас гаргасан Инчеоны тунхаглалыг хэрэгжүүлэх, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, халамж, нийгмийн хамгааллын тухай хуулийг шинэчлэн найруулах, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зэргийг боловсруулан батлуулах ажлын хэсэгт амжилттай ажиллаж ирсэн явдал юм. Энэ бүхэн нь тус холбооны ажилтнуудын мэдлэг чадвар, бусдын төлөө гэсэн нэгдмэл санаагаар ажиллаж байдгийн тод жишээ болно.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	ОХУ-ын Өвөр байгалын хот ,муж болон БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны зарим аймгуудтай хамтран ажилладаг.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	2009 онд ҮЭ-ийн холбооны дэргэдэх Эхлэл сургалтын төвийн чадавхийг бэхжүүлэх төсөл дээр хамтран ажилласан.






**Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо**

Байгууллагын нэр	Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо
Үүсгэн байгуулагдсан он	2005 он
Хаяг	Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Номин юнайтедийн өргөтгөл 8-3тоот
Утасны дугаар	75952929, 89982929
E-mail	Wheelchairusersmongolia@gmail.com
URL/Facebook	www.facebook.com/MNAWU/
Төлөөлөгчийн нэр	Тэргүүн Б.Чулуундолгор Ерөнхий менежер П.Сарангоо
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо нь гишүүдээ нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулан мэдээллээр хангаж, сэтгэл зүйн болон оюуны дэмжлэг үзүүлэх замаар амьдралын чадавхийг нь сайжруулах, тэргэнцэртэй иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус, төрийн бус байгууллага юм. Манай холбоо нь одоогоор Дархан-Уул, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Хэнтий, Сэлэнгэ аймгуудад салбар зөвлөл байгуулан ажиллаж байна.</p> <p>Зорилго: Төрийн үйлчилгээ, олон нийтийн хандлагыг ээлтэй, хүртээмжтэй болгох замаар хөдөлгөөний хязгаарлалттай болон тэргэнцэртэй иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаална.</p> <p>Зорилт</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үндэсний болон орон нутгийн бодлогыг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нийцүүлэх</li> <li>2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн саадгүй зорчих, нийгмийн үндсэн үйлчилгээнд бусдын адил хамрагдахад тулгар ч буй дэд бүтцийн хүртээмжийг сайжруулахад нөлөөлөх</li> <li>3. Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, тэдэнд хүрэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр олон талт үйл ажиллагааг зохион байгуулах</li> <li>4. Гишүүдийг чадваржуулах, идэвхжүүлэх, мэдээллээр хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих</li> </ol> <p>Хөтөлбөрүүд</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Гишүүдийн оролцоог нэмэгдүүлж нийгмийн дэмжлэгийг зуучлах хөтөлбөр</li> <li>2. Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр</li> <li>3. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг чадваржуулах хөтөлбөр</li> <li>4. Олон нийтийн болон бодлогын нөлөөллийн хөтөлбөр</li> </ol>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Финляндын ФЛОМ Олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн дэмжих бүлгүүдийг чадваржуулах замаар тэдэнд хүрэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахад нөлөөлөх нь” төсөл
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	“Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих нь” төсөл (2016-2020)



### 1. Гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа



### 2. Хөдөлмөр эрхлэлт ХБ эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “ЭКОГИФТ” хоршоо



### “Эрчис” тэргэнцэр засвар



### 3. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг чадавхжуулах





### Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоо

Байгууллагын нэр	Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоо /МХҮХ/
Үүсгэн байгуулагдсан он	1978 он
Хаяг	Хан-Уул дүүрэг, Чингисийн Өргөн Чөлөө, Хараагүй Хүмүүсийн Хөдөлмөр Сургалт хөгжлийн Төвийн байр Б корпус
Утасны дугаар	70044179, 8657444, 88077700
E-mail	info@mfnb.mn
URL/Facebook	Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо
Төлөөлөгчийн нэр	МХҮХ-ны ерөнхийлөгч Д.Ганбат, Ерөнхий нарийн бичгийн дарга Ш. Оюунбат
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>МХҮХ нь 1978 онд Монголын хараагүй, дүлий иргэдийн нийгэмлэг нэртэйгээр байгуулагдсан. 1993 онд Монголын хараагүйчүүдийн нийгэмлэг, 2005 оноос Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо болж, үйл ажиллагаагаа явуулж байна. Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо /МХҮХ/ нь хараагүй иргэдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин соёл урлаг, спорт, эрүүл мэндийн чиглэлээр төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж, гишүүдийнхээ эрхийг хамгаалах, нийгмийн харилцаанд оролцоход нь бүх талын дэмжлэг үзүүлэх зорилготой ашгийн бус, төрийн бус олон нийтийн байгууллага юм. МХҮХ нь Дэлхийн Хараагүйчүүдийн Холбоо, Ази номхон далайн бүс нутгийн хараагүйчүүдийн холбоо, Олон улсын хараагүйчүүдийн спортын нийгэмлэгийн гишүүн байгууллага билээ. МХҮХ нь олон улсын болон үндэсний хэмжээнд хараагүй иргэд, тэдний эрх ашигтай холбогдсон бүхий л асуудалд анхаарал хандуулж, байр сууриа илэрхийлсээр ирсэн хараагүй иргэдийн эвлэлдэн нэгдсэн цорын ганц байгууллага юм. Тус холбоо хот, хөдөөгийн салбараараа дамжуулан улсын хэмжээгээр нийт 10.800 орчим бүрэн хараагүй болон сул хараатай гишүүдийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд холбоо дэргэдээ дараах 5 салбар зөвлөлтэй. Үүнд: Ахмадын салбар зөвлөл, Эмэгтэйчүүдийн салбар зөвлөл, Залуучуудын салбар зөвлөл, Урлагийн салбар зөвлөл, Спортын салбар зөвлөл тус тус ажиллаж байна. Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны харьяанд ярьдаг болон брайль ном хэвлэх төв, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, "BEST FM - 98.5" радио станц, "BEST MASSAGE" сүлжээ төв, "Нарны Хаан Хүүхдүүд" цэцэрлэг, "CAFE MORE" байдаг.</p> <p>Брайль болон Ярьдаг ном хэвлэх төв" нь хараагүй иргэдийг мэдээллээр хангах, боловсрол мэдлэгээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа явуулдаг. 2004 оны 2-р сарын 19-ны өдөр Азийн хөгжлийн банкны санхүүжилт, Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төслийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан. Тус хэвлэлийн төв нь Брайль ном хэвлэх төв, Ярьдаг номын студи гэсэн хоёр хэсгээс бүрддэг. "Брайль" хэвлэлийн төв нь - тусгай зориулалтын хэвлэлийн тоног төхөөрөмжөөр, "Брайль" цаасан дээр, товгор үсэгтэй (Брайль үсэг) тэмтрэн унших номыг хэвлэдэг бол "Ярьдаг" номын студи нь - аливаа ном хэвлэлийг дэйзи форматад хөрвүүлж ярьдаг ном болгон хэвлэж байна.</p> <p>Мэргэжлийн Сургалт, Үйлдвэрлэлийн Төв нь Монгол улсын хэмжээнд харааны улмаас хөдөлмөрийн чадвараа 50 буюу түүнээс дээш хувиар алдсан МХҮХ-ны гишүүн хараагүй иргэдэд мэргэжлийн боловсрол олгох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хангахад чиглэгддэг бөгөөд үндсэн 5 мэргэжилээр боловсрол олгодог. Үүнд: Эмчилгээний бариа засалч, Эсгий, бэлэг дурсгалын зүйл урлаач, Хүртээмжтэй технологийн мэргэжилтэн, Ардын гоцлол хөгжимчин, Алжаал тайлах бариа засалч.</p> <p>Бэст ФМ 98.5 радио нь 2004 оны 12-р сарын 12-ны өдөр анх нэвтрүүлгээ цацаж эхэлсэн түүхтэй ууган фм-үүдийн нэг юм. Радио нь "Бид зөвхөн шилдгийг танд" гэсэн уриатайгаар ажиллаж байгуулагдсан цагаас өнөөдрийг хүртэл хамгийн шинэлэг дуу хөгжим мэдээ мэдээлэл нэвтрүүлгүүдийг таны сонорт хүргэж сонсогчдоосоо өндөр үнэлгээ авч чадсан бөгөөд сүүлийн 5 жилийн байдлаар "Монголын Хэвлэлийн Хүрээлэн" болон бусад судалгааны агентлагуудын судалгаагаар хамгийн олон сонсогчтой радиогоор тогтмол шалгарсан. Монгол улсад бусад fm радионуудаас анх удаа үндэсний хэмжээнд буюу Улаанбаатар хот төдийгүй Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Архангай, Өвөрхангай, Ховд, Увс, Хөвсгөл, Сэлэнгэ аймгууд /одоогоор/-д нэвтрүүлгээ шууд дамжуулдаг.</p> <p>Бэст массаж сүлжээ нь алжаал тайлах массаж болон бариа заслын мэргэжил эзэмшсэн хараагүй иргэдийг нэгдсэн зохион байгуулалттайгаар хөдөлмөр</p>

	<p>эрхлүүлж, тэднийг тохиромжтой ажлын байраар хангаж, иргэд олон нийтэд тохь тухтай, найрсаг орчинд Мэргэжлийн массажистууд уламжлалт бариа засал болон алжаал тайлах массажийн өндөр зэрэглэлийн чанартай үйлчилгээ үзүүлдэг сүлжээ юм. 2005 онд МХҮХ-ийн дэрэгдэх хараагүй хүмүүсийн нөхөн сэргээх сургалтын төвд Япон улсад мэрэгжил дээшлүүлсэн багш нарын удирдлаганд доор мэрэгжил эзэмшүүлэн төгсгөсөн анхны харааны бэрхшээлтэй массажистуудыг ажлын байраар хангах зорилтын хүрээнд 2007 онд Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбооны санаачлагаар Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дэмжлэгээр үүсгэн байгуулагдсан. 2007 онд БЭСТ МАССАЖ 1 дүгээр төвийг, 2009 онд БЭСТ МАССАЖ 3 дугаар төвийг тус тус байгуулан үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн өндөр түвшинд үнэлэгдсэн таатай орчин нөхцөлд үйлчилгээ үзүүлж байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу Нийслэлийн Боловсролын газраас тусгай зөвшөөрөл авч, 2 бүлгийн 14 хүүхдийн хүчин чадалтай, нийт 9 ажилчин албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна. Манай цэцэрлэгт бакалавр-6 хүн, коллеж-1 хүн, бүрэн дунд-2 хүн төгссөн ба мэргэжлийн багшлах эрхтэй багш 2, туслах багш-3, тогооч-1, арга зүйч, менежер-1, эрхлэгч-1, эмч-1 гэсэн орон тооны бүтэцтэй ажиллаж байна.</p> <p>Харааны бэрхшээлтэй иргэдэд тохирох ажлын байрны нэг нь баристагийн мэргэжил бөгөөд бусад улс орнуудад энэхүү мэргэжлээр харааны бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. МХҮХ болон Солонгосын хараагүйчүүдийн “Шилоам” байгууллагатай хамтран Койка байгууллагын санхүүжилтээр 2017 оноос эхлэн төсөл хэрэгжиж харааны бэрхшээлтэй иргэнд баристагийн мэргэжил эзэмшүүлэн дээрх баристагийн мэргэжил эзэмшсэн харааны бэрхшээлтэй иргэдийг тогтмол байнгын ажлын байраар хангах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр “Café more” кофе шопыг 2018 оны 7 сард ХНХЯ-ны өргөтгөлийн 1 давхарт тохь тухтай цэвэр цэмцгэр орчинд, мэргэжлийн өндөр түвшинд нийтэд үйлчлэн ажиллаж байна.</p>
<p>Япон болон олон улсын хамтын ажиллагаа</p>	<p>МХҮХолбоо болон Японы Токио Тама мужийн “Хараагүйчүүдийн холбоо”той хамтын ажиллагаа эхлүүлж, тэдний үйл ажиллагаанаас туршлага судлах, түншийн хүрээнд одоогийн ханшаар гурван сая төгрөгийн буцалтгүй тусламж манай байгууллагад өгч байв. 1999 он Японы Олон улсын хараагүйчүүдийг дэмжих нийгэмлэг /International Assacotion for the visually impaired/ Монголын харааны бэрхшээлтэй залуучуудыг Япон улсад суралцахад батлан дааж, хамтран ажиллав. Хамтын ажиллагаа эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл 7 хүн суралцсанаас зарим оюутан төгсөж, зарим оюутнууд суралцаж байна. Японы хараагүйчүүдийн төв номын сан санаачлан МХҮХ-той хамтран “IT-ийн сургалт” явуулж, манай байгууллагаас 5 хүн энэ чиглэлээр хичээл авч байна. Япон орны бариа заслыг азийн орнуудад түгээн дэлгэрүүлэх зорилготой Японы “Amin” бариа заслын байгууллага хамтран ажиллаж, энэ хүрээнд МХҮХолбоо Amin байгууллагын хөтөлбөрт тулгуурлаж өөрийн шинэ байгуулагдаж буй бариа заслын салбарын хөтөлбөрийг боловсруулсан болно. 2007-2013 он 2006-2023 Данийн хараагүйчүүдийн нийгэмлэгтэй хамтран хараагүйчүүдийн байгууллагыг чадавхижуулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Малайз, Тайланд, Солонгос зэрэг орнуудын хараагүйчүүдийн байгууллагуудтай хамтран ажиллаж монголын хараагүй иргэдийг компьютер, массаж, баристагийн чиглэлээр урт болон богино хугацааны сургалтуудад хамруулдаг.</p>
<p>ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр</p>	<p>2004 онд Дэлхийн Хараагүйчүүдийн холбоо, Ази номхон далайн бүс нутгийн хараагүйчүүдийн холбоо, Японы Хараагүйчүүдийн Хороо, Японы Засгийн Газар, “ЖАЙКА” байгууллагаас хэрэгжүүлсэн Ази Номхон Далайн Бүс Нутгийн хөгжиж буй орнуудын хараагүйчүүдийн дунд массажийн багш бэлтгэх сургалтад Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбооноос 4 харааны бэрхшээлтэй иргэнийг 2008-2012 онд Японы Цүкүба их сургуулийн харьяа Хараагүйчүүдийн массажийн сургуульд зүү төөнүүрч массажистийн мэргэжлээр сургаж бэлтгэсэн.</p> <p>Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлж буй “УБ хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих” төслийн хүрээнд 2016-2020 хөгжлийн бэрхшээлтэй ба тэгш байдлын тухай сургалтад 5 харааны бэрхшээлтэй иргэний хамруулж сургагч багшаар бэлтгэсэн.</p>

## Энэрэлийн Түүчээ

Байгууллагын нэр	Энэрэлийн Түүчээ ТББ
Байгуулагдсан он	2012 он
Хаяг	Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Сүмбэр тауэр 16
Утасны дугаар	89008668, 89069935, 89011691
E-mail	info@etuuchee.mn, project@etuuchee.mn
URL/Facebook	<a href="https://www.facebook.com/tuuchee.tbb">https://www.facebook.com/tuuchee.tbb</a>
Төлөөлөгчийн нэр	Б. Диваа /Төслийн менежер/
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Энэрэлийн Түүчээ ТББ нь 2012 онд үүсгэн байгуулагдсан. Өнөөдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүслийн Ордон тусгай цэцэрлэг нь 4 бүлэг, 40 гаруй хүүхэдтэйгээр, боловсролын болон сэргээн засахын үйлчилгээг хүүхдүүдэд бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр хүргэж, эцэг эхэд зориулан сургалт зохион байгуулан ажиллаж байна.</li> <li>- Сургалт-судалгааны төвөөрөө дамжуулан тэгш хамруулах боловсролын үзэл санаа, үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулж эхэлснээр судалгаа хийж, сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах ажил явагдсаар байна.</li> <li>- Явуулын үйлчилгээний гэрээр үзүүлэх үйлчилгээгээр боловсрол, сэргээн засах болон халамжийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй, амьжиргааны түвшин доогуур өрхийн, тусгай хэрэгцээт хүүхдийн онцлог, хэрэгцээнд тохирсон хөгжүүлэх сургалт, сэргээн засах үйлчилгээг тухайн хүүхдийн гэрт нь очиж хүргэдэг.</li> <li>- Урлан хөтөлбөр Бага насны хүүхдийн тархины хөгжлийг дэмжих, гэр бүлийн хамтын үйлийг цэцэглүүлэх, мэргэжилтнүүдийн хичээл зүтгэлийг баяжуулах төрөл бүрийн бүтээгдэхүүнийг даавуу, ноосон материалаар нэг бүрчлэн гараар урлан бүтээж байна.</li> <li>- Шилжилтийн хөтөлбөр нь оюуны бэрхшээлтэй залуусын бие даан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор оюуны бэрхшээлтэй залуусыг хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шилжилтийн хөтөлбөрийг эхлүүлэв.</li> </ul>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ol style="list-style-type: none"> <li>1. ХБНГУ-ын Заксен мужийн залуусын тэтгэлгийн сангийн дэмжлэгтэйгээр тусгай хэрэгцээт хүүхдийн боловсролыг дэмжин СӨБ-ын багш, туслах багш, тусгай хэрэгцээт хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчид, үйлчилгээ үзүүлэгчид, холбогдох байгууллагын мэргэжилтэн чадавхжуулах төсөл</li> <li>2. Мицүбиши Корпорацын санхүүгийн дэмжлэгтэйгээр олон жилийн судалгаанд үндэслэсэн, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын ICF-CY (Үйл ажиллагааны олон улсын ангилал-Хүүхэд/Залуучууд) тулгуурлан боловсруулсан энгийн үг хэллэгтэй, цахим болон цаасан хувилбар бүхий, нярай, балчир насны хүүхдийн хөгжлийн түвшин тогтоон, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх үнэлгээний программыг туршилтын төсөл</li> </ol>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



## Ээлтэй ертөнц

Байгууллагын нэр	Ээлтэй ертөнц ТББ
Байгуулагдсан он	2009 он
Хаяг	Хан-Уул дүүрэг,4-р хороо, Вива сити хороолол, N1 block
Утасны дугаар	9411568
E-mail	Tuya2278@gmail.com
URL/Facebook	<a href="https://www.facebook.com/MercifulWorld">https://www.facebook.com/MercifulWorld</a>
Төлөөлөгчийн нэр	Т.Туяажаргал
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Ээлтэй ертөнц ТББ нь байнгын асаргаа шаардлагатай хүүхдийг бие хүн болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдний асран хамгаалагчдын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхэд нөлөөлөх чиглэлээр 2009 оноос өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулж байгаа билээ. Зорилтын дагуу ЭНЭРЭЛ хүүхэд хөгжүүлэх төвийг эхлүүлэн 4 дэх жилдээ тархины саа булчингийн чангарал оноштой 12 хүүхэд, оюуны хүнд хэлбэрийн бэрхшээлтэй 12 хүүхдэд бүтэн цагийн үйлчилгээг үзүүлж байна.</p> <p>Эдгээр хүүхдүүдийн хувьд оюуны хөгжлийн онцлог ялгаатай байдал нь нийгэмд бие даан оролцох боломжийг нь хязгаарлаж байгаа ч хүний тусламжтайгаар үйлдлүүдийг хийх боломжтой байдаг. Бидний төлөвлөгөөгөөр 5 жилийн дараа ханни зөөлөн тоглоомны үйлдвэрийн туслах ажилтан болох хэмжээнд бэлтгэгдсэн байхаар ганцаарчилсан хөтөлбөр боловсруулсан юм.</p> <p>Байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй асран хамгаалагчдын оролцоог хангах, хамтран ажиллаж байж хүүхдийн хөгжлийн хөтөлбөр үр дүнтэй байх учраас аав, ээжүүдийг оролцуулсан цагуудыг гаргаж, сургалтууд зохион байгуулсан юм. Ингэснээр үйл ажиллагаа илүү чанартай хүрэх, хөгжүүлэх төв болон гэртээ үйлдлүүдийг адилхан зааж суралцах нөхцлийг бүрдүүлж байгаа юм.</p> <p>Ээлтэй Ертөнц ТББ-ын дэргэдэх Энэрэл хүүхэд хөгжүүлэх төв нь 2021-2022 оны хичээлийн жилд хөтөлбөртөө хөгжимт засал /music therapy/ нэмэлтээр оруулж байгаа бөгөөд 2 бүлгийн хүүхдүүдэд эерэг нөлөө үзүүлж байгаа юм.</p> <p>Зөвхөн нүдээ хөдөлгөх чадвартай хүүхэд хүртэл хөгжмийн хойно суулгаад багшийн заавраар хөгжмийн даралтанд хүрэхэд булчингаа ажиллуулах сонирхолтой болж, гараа өөрөө хөдөлгөх оролдлогууд хийж байгаа нь бидний хөгжлийн үйл ажиллагаанд чухал нэг ажил болж байна.</p> <p>Оюуны бэрхшээлтэй хүүхдийн хувьд гитар хөгжимтэй хөтөлбөрүүд бэлтгэсэн нь анхаарал төвлөрөх, хөг аялгууны дагуу үйл хөдлөл хийх зэрэг хөдөлмөр заслын нэгэн хэсэг болоход үр дүнтэй байна.</p> <p>Энэхүү төвийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсад анх удаа асран хамгаалагчдын ажлын байр зөөлөн тоглоомны үйлдвэрийг эрхэлж байгаа бөгөөд борлуулалтаас санхүүжилтээ шийдэн, хүүхдүүдээ авч байгаа юм.</p> <p>Ханни зөөлөн тоглоом нь 2011 оноос өрхийн үйлдвэрлэл болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч буй ээжүүдийг орлоготой болгох зорилгоор эхэлж байлаа. Энэ хугацаанд 100 гаран эмэгтэйчүүд оролцож, багахан халамжийн тэтгэмжээс гадна хүүхдийнхээ хэрэглээнд зориулах орлоготой болсон юм. Жижигхэн өрхийн үйлдвэрлэлд олон асран хамгаалагчид нэгдсэнээр монгол улсад нэн хэрэгцээтэй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хөгжүүлэх төв байгуулж, зөөлөн тоглоомны үйлдвэртэй болох том мөрөөдөл, зорилгыг бий болгосоноор 7 жилийн дараа Ханни зөөлөн тоглоомын үйлдвэрийг түшиглэсэн 24 хүүхэд хөгжүүлэх төв байгуулагдсан билээ. Хүүхэд хөгжүүлэх төвийн санхүүжилтийг төрөөс дэмжих тогтолцоо байхгүй учир энэхүү үйлдвэрээс гарч буй бүтээгдэхүүний ашгаар хүүхдүүдээ асарч, хөгжүүлэх боломжийг бүрдүүлж байгаа билээ.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	“Мицүбиши” корпорацийн дэмжлэгийг 2018, 2019 онуудад авч байсан.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Хамтарсан төсөл хийж байгаагүй.





**ХАННИ**  
ЭРЭГЭЙН ХӨДӨӨ

маш хялбархан

БИДНИЙ ОРОЛЦОО

"Ээлтэй Ертөнц" ТББ since 2009  
Байнгын осаргаа сувилгаа шаардлагатай  
хүүхдэд ЭЭЛТЭЙ орчин бүрдүүлгээ

Фэйсбүүк хуудас: Ээлтэй Ертөнц ТББ New Merciful World NGO,  
Хөвчө зөвлөлөгч тогтоосон.  
Хүүхдэд хөгжүүлэх Энэрэл төв  
Хаяг: Хан-Уул дүүрэг 4-р хороо, Вива сити хороолол N1 Блок  
Утас: +976-94115568.

ЭЭЛТЭЙ ЕРТӨНЦ  
ТӨРИЙН ЭС ВЭЛГҮҮЛГЭЭ  
since 2009

**ХАННИ**  
ЗӨВЛӨН  
ТОГЛОМ

Хүний талнаа идмэлх зүрх бүхэн аригч байх  
Хүүхдийн талнаа тэмүүлэх зам мөр тгшч байх  
"Ээлтэй Ертөнцийнхон"

**Бид чадна эм эн нэгдэл**

Байгууллагын нэр	Бид чадна эм эн нэгдэл ТББ
Байгуулагдсан он	2013 он
Хаяг	Баянгол дүүрэг, 7-р хороо, 12-220
Утасны дугаар	99741916
E-mail	bidchadnadpo@gmail.com
URL/Facebook	<a href="https://www.facebook.com/BidchadnaMN">https://www.facebook.com/BidchadnaMN</a>
Төлөөлөгчийн нэр	Отгонтуяа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх тэгш ажиллаж, амьдрах боломжтой орчинг бүрдүүлэх, ажлын орон тоог нэмэгдүүлэх, нийгмийн хариуцлагатай ажил олгогчдыг дэмжиж сурталчлах, нийгэмд эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор bidchadna.mn цахим хуудсыг хөгжүүлэх ажлыг 2011 онд олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд санаачлан эхлүүлсэн. 2013 онд тус цахим хуудсын үйл ажиллагаанд тулгуурлан “Бид чадна эм эн нэгдэл” ТББ байгуулагдаж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэдээллээр хангах, чадавхжуулах, соёл урлагаар дамжуулан нийгэмд таниулах чиглэлээр ажиллаж байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх хандлагыг өөрчлөх зорилгоор Тэргэнцэртэй иргэдийн хувцас загварын шоу, Тэргэнцэртэй сайхан бүсгүй үндэсний тэмцээн, Учрал олон улсын контемпрари бүжгийн төсөл, их дээд сургуулийн оюутнуудыг сайн дурын ажил хийхэд чадавхжуулах Бид чадна сайн дурын хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй залуусд зориулсан “Амжилтын гараа” менторшип хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах, үзэл бодлыг нь түгээх “Зөрлөг” тэргэнцэртэй хүүхдийн үйл явдалт цуврал зурган номууд зэрэг соёл урлаг, хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх дотоодын болон олон улсын олон арван төслийг санаачлан хэрэгжүүлсэн.</p> <p>УЗ-ийн Сайн дурын 5 гишүүнтэй, нийгэмдээ үйлчлэх хэлбэрээр ажилладаг байгууллага юм.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>DPUB буюу Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн оролцоог нэмэгдүүлэх төслөөс зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын сургалтанд манай байгууллагын үүсгэн байгуулагч Б.Отгонтуяа, Х.Батчимэг нар сууж сургагч багш нар болсон ба манай байгууллагаас зохион байгуулдаг их дээд сургуулийн сайн дурын хөтөлбөрийн оролцогч оюутнуудад болон хувийн хэвшлийн мөн төрийн байгууллагуудад одоогоор нийт 500 орчим хүнд заагаад байна Х.Батчимэг нь сургагч багш нарын ТББ-ын УЗ-ийн даргаар ажиллаж, үйл ажиллагааг нь давхар хариуцан ажиллаж байна.</p> <p>Б.Отгонтуяагийн хувьд ЖАЙКА DPUB төслийн ТББ-уудыг төлөөлсөн Хамтарсан зөвлөлд 2016-2020 онуудад гишүүнээр ажиллаж байсан ба тус зөвлөлөөс зохион байгуулсан Тайландын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах ТББ-уудын сүлжээг судлах сургалтанд оролцож Ази Номхон Далайн Орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв дээр очиж туршлага судалж байсан.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй







**Сайн найз төв**

Байгууллагын нэр	“Өгөөмөр Сэтгэл Нийгэмлэг” ТББ-ын дэргэдэх “Сайн Найз” төв
Байгуулагдсан он	“Өгөөмөр Сэтгэл Нийгэмлэг” ТББ- 2006 он “Сайн Найз” төв -2014 он
Хаяг	Баянзүрх дүүрэг,17-р хороо,Эрдэнэтолгой 35-924
Утасны дугаар	89555755,96889713
E-mail	uguumursetgeltbb@gmail.com,gkeymn@gmail.com
URL/Facebook	Сайн Найз   Facebook
Төлөөлөгчийн нэр	Ж.Алтантүлхүүр
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>“САЙН НАЙЗ” төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусын эрхийг хүндэтгэн тэднийг хөгжиж нийгэмшихэд нь дэмжин туслах, тэдний эцэг эх асран хамгаалагчид, мэргэжилтнүүд, нийгэм хамт олны хандлагыг өөрчлөн чадваржуулах үйл ажиллагаа болон сургалт хөтөлбөрүүдийг зохион байгуулдаг байгууллага юм.</p> <p>Бид хүүхэд залуусын нийгэм дэх тэгш оролцоог чухалчлан үзэж хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлалгүй үе тэнгийн найз нөхдийнх нь дунд сурган хөгжүүлж хөдөлмөрийн чиг баримжаа олгон хөдөлмөрлөх боломжоор ханган бүтээлч иргэн болон төлөвшихөд нь тусалж байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусыг найз нөхөдтэй нь хамтад нь үйл ажиллагаандаа оролцуулах нь хөгжлийн бэрхшээлийн талаарх эерэг хандлагыг нийгэм орчиндоо өгч бие биенээ ойлгон дэмжиж хамтран ажиллах нөлөөлөл болж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Бид бямба гараг бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тэдний эцэг эх асран хамгаалагчдыг чадваржуулах “Нинжин” өдрийг Япон Улсын “Ninjin” ТББ-тай хамтран зохион байгуулдаг.</p> <p>‘Young Life Mongolia’ олон улсын байгууллагатай хамтран хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зуны зуслан зохион байгуулж байна.</p> <p>Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын дэмжлэгээр халаалттай болсон нь тогтмол үйл ажиллагаа явуулахад маш их дэмжлэг болсон.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	<p>2016-2019 онуудад ЖАЙКА-гийн Өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд “Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн тусламж үйлчилгээг сайжруулах, эцэг эх, мэргэжилтнийг чадавхжуулах төсөл”-ийг хэрэгжүүлсэн.</p>



**Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо**

Байгууллагын нэр	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо ТББ
Байгуулагдсан он	2009 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, СЗСҮТөвийн байрны 203 тоот
Утасны дугаар	99994444, 95044444
E-mail	Nkh.uadm@gmail.com
URL/Facebook	Монголын ХБИ-ийн Нэгдсэн холбоо Page хуудас
Төлөөлөгчийн нэр	Д.Баатаржав
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Нэгдсэн Холбоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг 40 гаруй ТББ-уудыг эгнээндээ нэгтгэн, үйл ажиллагааг нь нэгдсэн бодлого удирдлагаар хангах, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц” -ийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран үйл ажиллагаа явуулдаг.</p> <p>Үйл ажиллагааны үндсэн чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ОУ –ын гэрээ конвенц, ХБХүний эрхийн тухай хууль болон үндсэн хууль, бусад хуульд заасан эрх ашгийг хамгаалах олон талт үйл ажиллагаа явуулах</li> <li>✓ Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангах, чиглүүлэх, хамтран ажиллах</li> <li>✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх нийгмийн сэтгэл зүйг өөрчлөх, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж мэдээлэл сурталчилгаа, сургалтын үйл ажиллагаа явуулах</li> <li>✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд бүх талаар тэгш оролцох оролцоог хангахын тулд боловсрол, соёл, урлаг, спорт, эрүүл мэндийн чиглэлийн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах</li> <li>✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амжиргааг сайжруулах, дээшлүүлэхийн тулд төрийн болон ТББ-тай хамтран хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц үйл ажиллагаа явуулахад хамтран ажиллах Чиглэлүүдийг баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна.</li> </ul>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• Олон улсын Хөдөлмөрийн байгууллага, Монголын ҮЭХолбоо, Ажил олгогч эздийн холбоотой хамтран “ХБИ-ийг хөдөлмөрт бэлтгэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх” төсөл 2011 он</li> <li>• АИФО ОУ-ын байгууллагын дэмжлэгтэйгээр ХБХЭТКонвенцийн анхны тайлан илтгэлийг ТББ-уудтай хамтран бичиж тайлан хамгаалах хуралдаанд оролцож ажилласан. 2015 он</li> <li>• АИФО ОУ-ын байгууллагын дэмжлэгтэйгээр Удирдлагын академийн ХБИ-ийн ТББ-ын удирдлагуудыг чадавхижуулах сургалт хөтөлбөр 2013 он</li> <li>• Каритас чех репалик “Залуучуудын хөдөлмөрт эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрт 2020 онд</li> <li>• АНУ-ын элчин сайдын яам “АНУ-ын ХБИ-ийн байгууллагатай онлайн уулзалтыг зохион байгуулж “ХБХүний эрхийн тухай хуулийг санаачлах ажлыг эхлүүлэн ХНХЯ болон ТББ-ын төлөөллүүд АНУ-д албан ёсны айлчлал хийсэн 2015 он</li> <li>• Австралийн засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн зохицуулах хороонд ажиллаж ХБИ-ийг хөтөлбөрт хамруулах чиглэлээр санал оруулан шийдвэрлүүлсэн 2019 оноос одоог хүртэл ажиллаж байна</li> <li>• Япон улсын Шизүока мужийн ХБИ-ийн байгууллагатай хамтран тэдний дэмжлэгтэйгээр Нисдэг тавагны спортыг хөгжүүлэх ажлыг эхлүүлэн одоо энэ чиглэлээр Нисдэг тавагны холбоо байгуулан Шизүока мужтай хамтран ажиллаж байна. 2017 он</li> <li>• БНСУ-ын Чэжү хотын ХБИ-ийн байгууллага, спортын холбоотой хамтран ХБИ-ийн туршлага солилцох, аялал жуулчлалд хамруулан ажлыг эхлүүлэн</li> </ul>




	<p>ажиллаж байна. /цар тахлаас шалтгаалан 2 жил саатаад байна/ 2018 оноос одоог хүртэл</p> <ul style="list-style-type: none"> <li>• НҮБ -ын “Хөгжлийн хөтөлбөртэй хамтран ХБ-тэй залуучуудын хөгжлийн саадыг арилгая” хөтөлбөр 2014 он</li> </ul>
<p>ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр</p>	<p>ЖАЙКА-гаас хэрэгжүүлэн ажиллаж байгаа төсөл хөтөлбөрт гишүүн ТББ-уудыг DET -ийн сургагч багш нарыг бэлтгэх хөтөлбөрт хамруулан ажилласан.</p>



## DET форум

Байгууллагын нэр	DET форум- Бэрхшээл ба тэгш байдлын сургалт форум
Байгуулагдсан он	2017 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо ,Баянзүрх хотхон 109-р байр 58 тоот
Утасны дугаар	85110109, 94230846
E-mail	detforummongolia@gmail.com
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	Тэргүүн Б.Энхням
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Манай сургалтын үндсэн үүрэг бол НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцын үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлэхэд оршино. DET сургалтын гол зорилго нь бүх хүнд хүртээмжтэй нийгмийг бүтээх юм. DET сургалт нь нийт 46 сургагч багштай бөгөөд бүгд хөгжлийн бэрхшээлтэй багш нар байдгаараа давуу талтай.</p> <p>Сургалтад ашигладаг сургалтын материал болон видео контент бүгд зохиогчдын эрхтэй учраас DET-ын сургагч багш нараас өөр бусад хүн ашиглах боломжгүй байдаг.</p> <p>DET сургалтын стандарт хугацаа 3 цаг байдаг бөгөөд үндсэн 2 хэсгээс бүрдэнэ.</p> <p>1-р хэсэг буюу эхний 1 цаг 30 минутад Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ? Хөгжлийн бэрхшээл хаана байна вэ? гэсэн агуулгын хүрээнд оролцогчид багаар ярилцан 3 дасгал ажил ажиллана.</p> <p>2-р хэсэг буюу сүүлийн 1 цаг 30 минутад Бид юу хийж чадах вэ? гэсэн агуулгын хүрээнд багаараа үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж эдгээр асуудлын шийдлийг олох цогц сургалт юм.</p> <p>DET сургалтын багын бүрэлдэхүүнд 2 үндсэн багш, сургалтад оролцож байгаа оролцогчийн тооноос хамаарч багын чиглүүлэгч багш нар мөн 2 туслах ажилтан байна.</p> <p>Сургалтын хэлбэр: Багаар ажиллах</p> <p>Сургалтын төрлүүд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Бэрхшээл ба тэгш байдал сургалт (DET)</li> <li>2. DET+ ХБИ хэрхэн зөв туслалцаа үзүүлэх вэ?</li> <li>3. DET+ХБХүний Эрхийн тухай хууль</li> <li>4. DET+ХБИ эрхийн тухай конвенц</li> <li>5. DET+стандарт</li> <li>6. DET танилцуулах сургалт</li> </ol>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	DET форумын сургагч багш нарыг DPUB төслөөр дамжуулан чадваржуулсан.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	<p>DPUB төслөөр дамжуулан DET форум нь Япон улстай туршлага солилцох 14 хоногийн сургалт зохиол байгуулсан.</p> <p>JICA DPUB төсөлтэй хамтран 10,000 хүнд DET сургалтыг хийсэн.</p> <p>JICA START төсөлтэй хамтран DET-ын сургалтуудыг зохион байгуулсан.</p>





## Батэгшиглэн

Байгууллагын нэр	Батэгшиглэн ТББ
Байгуулагдсан он	2007 он
Хаяг	Баянгол дүүрэг ,1-р хороо ,57-67
Утасны дугаар	94161919,88189106
E-mail	Yundenbaterdene68@gmail.com
URL/Facebook	Yunden Baterdene
Төлөөлөгчийн нэр	Ю.Батэрдэнэ
Үйл ажиллагааны товч танилцуулга	1.Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Дэд бүтэц 2. Арьсан урлал зураг
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





## Хан-Уул бие даан амьдрах төв

Байгууллагын нэр	Хан-Уул бие даан амьдрах төв
Байгуулагдсан он	2014 он
Хаяг	Баянгол дүүрэг, 18-р хороо, АОС 5 тоот
Утасны дугаар	99853849
E-mail	khanuul.ilc@gmail.com
URL/Facebook	<a href="https://www.facebook.com/Хан-Уул бие даан амьдрах төв">https://www.facebook.com/Хан-Уул бие даан амьдрах төв</a>
Төлөөлөгчийн нэр	Ц.Энхтуяа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Хөгжлийн бэрхшээлийн хүндрэл, хэлбэрээс үл хамааран бие даан амьдрах үзэл баримтлалыг төлөвшүүлэн хэрэгжүүлэх, хүртээмжтэй саадгүй орчныг бий болгох, нийгмийн халамжийн үйлчилгээг улам боловсронгуй болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чадваржуулах зорилготойгоор үйл ажиллагаа явуулдаг гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага.</p> <p>Хан-Уул бие даан амьдрах төв нь дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулах зорилготой.</p> <ul style="list-style-type: none"> <li>· Хувийн туслагч</li> <li>· Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зөвлөлдөх үйлчилгээ</li> <li>· Сургалт, мэдээлэл</li> <li>· Нөлөөллийн ажил /Адвокси/</li> <li>· Хөдөлмөр эрхлэлт</li> </ul>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





## Монголын харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын холбоо

Байгууллагын нэр	Монголын харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын холбоо
Байгуулагдсан он	2016 он
Хаяг	Баянгол Дүүрэг, 18-р хороо, 83а байр ,2-р орц 1 давхарт
Утасны дугаар	77038003 ,94743838
E-mail	Go.bolormaa@gmail.com,mhbhzh01@gmail.com
URL/Facebook	Монголын харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын холбоо
Төлөөлөгчийн нэр	Гомбосүрэн Болормаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Манай байгууллага 2016 онд байгуулагдсан. Бид Харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын эрхийг хамгаалах, Эрүүл мэнд,боловсрол,хөдөлмөр эрхлэх,бие даан амьдрах ухааны ур чадвар олгох чиглэлээр үйл ажлгануудыг явуулдаг ашгийн бус төрийн бус байгууллага юм.</p> <p>Дээрхи үйл ажилгануудын хүрээнд сургалт хий,судалгаа явуулах,хуульзүйн болон сэтгэлзүйн зөвөлгөө өгөх,мөн төрийн болон тбб-тай хамтран ажиллах орон нутгийн болон олон улсын төсөл хөтөрбөрүүдийг хэрэгжүүлдэг.</p> <p>2019оноос эхлэн ХӨДӨЛМӨР ХАЛАМЖЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР-аас Сургалт явуулах,Зөвөлгөө өгөх" магадлан итгэлмжлэлээ авсан.</p> <p>2020 оноос эхлэн "ГЭР БҮЛ ХҮҮХЭД,ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН" "Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх" чиглэлээр магадлан итгэмжлэлтэй.</p> <p>Мөн манай байгууллагын дэргэдэх "Мөрөөдлийн байшин" хөгжлийн төв, "Сэтгэл зүйн боловсролын төв" – үүд маань үйл ажиллагаагаа амжилттай явуулсаар байна. "Мөрөөдлийн байшин хөгжлийн төвөөрөө дамжуулан харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудад соёл, урлаг, спорт, компьютер гадаад хэлний мэдлэгийг олгож байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Европын холбоо,Дэлхийн зөн ОУБ-тай хамтарсан "Хамтдаа даван туулья" төсөл.2021оны 4-р сараас 2022 оны 4-р сар
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	<p>1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмгдүүлэх төсөл хөтөлбөрт 2016-2020.</p> <p>2.ЖАЙКА-гийн ХБИ-дийн хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог сайжруулах төсөлд (суурь судалгаанд судлаачаар) 2021 оны 5-р сараас</p> <p>3.ЖАЙКА-гийн SATRT 2 төслийн бичил төсөлд 2021 оны 9-р сараас 2022 оны 6-р сар</p>



## Салхич шувуу

Байгууллагын нэр	Салхич шувуу ТББ
Байгуулагдсан он	2003 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг,4-р хороо, 50 мянгатын 22-40 тоот
Утасны дугаар	99746900, 96336668
E-mail	salkhichshuvuus@gmail.com,khandaa22@yahoo.com
URL/Facebook	Салхич шувуу ТББ пэйж хуудастай.
Төлөөлөгчийн нэр	“Салхич шувуу” төвийн Удирдах зөвлөлийн дарга, сэтгүүлч Д.Бадамханд
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>“Салхич шувуу” төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор багш-сэтгүүлч Долгорсүрэнгийн Бадамхандын санаачлагаар 2003 онд үүсэн байгуулагдсан. Мөн зорилгынхоо хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах хандлагыг эерэгээр өөрчлөхийн тулд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран радио телевизийн нэвтрүүлэг бэлтгэж түгээх, нийгмийн хандлагад нөлөөлөх үйл ажиллагаануудыг сайн дурын гишүүдийн оролцоотой зохион байгуулсаар ирсэн.</p> <p>“Салхич шувуу” төвийн үүсэн байгуулагдахад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр төдийлөн их байгаагүй. Гэсэн хэдий ч дэмжигч санхүүжүүлэгч, тухайлбал, Монголын эмэгтэйчүүдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр болон гэр бүлийн найзууд, сэтгүүлчдийн үүсгэн байгуулсан “Шинэ долгион 107.5 фм” радиогоор нэвтрүүлэг бэлтгэн хөтөлж, 2003-2007 онд “Амьдралын тойрог” радио нэвтрүүлгийг бэлтгэн хөтөлж байсан. Намайг ТББ-ыг ажиллуулахад найз нөхөд, сайн дурын гишүүд дэмжигчдээс тодорхой хэмжээгээр санхүүжүүлж, ХНХЯ-ны зүгээс Д.Бадамхандын номыг хэвлэгдэхэд 2019 онд санхүүжилт олгож байсан.</p> <p>Анх 1995 оноос мэдээлэл, уран сайхны “Амьдралын тойрог” сониныг сэтгүүлч Д.Бадамханд санаачлан 1995-2000 оны хооронд 5 дугаарыг эрхлэн гаргаж байсан боловч санхүүгийн зардал, маркетинг, менежментийн асуудлаас болоод цаашид эрхлэн гаргахаа зогсоосон байдаг. Д.Бадамханд нь өөрөө тулгуур эрхтэний бэрхшээлтэй эмэгтэй.</p> <p>“Салхич шувуу” төвийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн соёл мэдээллийн төв болгох хэтийн зорилготой.</p> <p>2013 онд “Салхич шувуу” төв үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойгоо Монголын Хүүхдийн ордонд тэмдэглэж, хамтран ажилладаг байгууллагуудын болон сайн дурын гишүүдийнхээ хүүхдүүдийн бүтээлээр гар зургийн үзэсгэлэн гаргаж, дуучид уран бүтээлчид хүндэтгэн ирж ая дуугаараа мэндчилгээ дэвшүүлэн оролцож байсан билээ.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	“Салхич шувуу” төв нь МХБИБҮХ-ны гишүүн байгууллагын зүгээс дэвэр холбооны хамтын ажиллагаа мөн бидний үйл ажиллагаанд шууд хамааралтай гэж ойлгодог. 1997 оноос хойш МХБИБҮХ-ны шугамаар Хятад, Солонгос, Орос, Япон, Герман, АНУ-ын Засгийн газар, Төрийн Департаментын санхүүжилтээр туршлага судлах бололцоо олдсонд маш их талархалтай явдаг. Цаашид ч хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нь хамтран ажиллах, туршлага судлах боломж олдоно гэдэгт итгэж явдаг.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	2016-2020 онд хэрэгжсэн Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх төслийн сургалтад хамрагдаж мэдээллүүдийг авч байсан. 2017 оноос хойш “Салхич шувуу” төв идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй байгаа нь төвийн тэргүүн ондоо ажилд шилжсэнтэй, мөн санхүүгийн үйл ажиллагаанаас ч хамааралтай, түүнчлэн төвд хамааралтай цөөн хэдэн залуус өөр өөрийн аж амьдралыг дөнгөж зохион үр хүүхэд төрүүлсэн гээд хүндэтгэх шалтгаантай.





## Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо

Байгууллагын нэр	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо
Байгуулагдсан он	2000 он
Хаяг	Баянгол дүүрэг, 20-р хороо, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 213 тоот
Утасны дугаар	70123336, 95907012
E-mail	info.apdcmongolia@gmail.com
URL/Facebook	Facebook page: APDC Mongolia , Website: www.apdc.mn
Төлөөлөгчийн нэр	С.Сэлэнгэ /Гүйцэтгэх захирал/
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>ЭРХЭМ ЗОРИЛГО: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусын эрхэм чанарыг хүндэтгэн, эрхийг нь бүрэн дүүрэн эдлүүлэх, нийгмийн амьдралд бие даасан, идэвхитэй иргэн болох нөхцлийг бий болгуулах зорилготой. Холбоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн санаачлагаар үүсгэн байгуулагдсан, 16 аймагт салбартай, 4300 гаруй гишүүдтэй. Төрөөс хүргэдэг бүхий л үйлчилгээг чанартай болгохын тулд эцэг эхчүүдийг мэдлэг, мэдээлэлтэйгээр оролцож, эрх мэдэлтэй болгохын тулд үндсэн үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.</p> <p>Манайд хэрэгжиж буй хөтөлбөрүүд</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хүүхэд хөгжлийн төвүүд /Бага насны хүүхдэд хөгжлийн дэмжлэг үзүүлэх, чөлөөт цагийн хөгжлийн арга хэмжээ зохион байгуулдаг/, Төрөөс ХБХдэд хүргэдэг үйлчилгээ байхгүй эсвэл дутагдалтай байдлаас үүдэн ХБХийн эцэг эхчүүд 2002 оноос эхлэн ХХТөвүүдийг байгуулсан байдаг юм. Хүүхэд хөгжлийн төв 7 аймагт байдаг. Баян-Өлгий, Баянхонгор, Дархан Уул, Дорнод, Орхон, Ховд, Хөвсгөл, Хүүхэд хөгжлийн кабинет 2 аймагт Дундговь, Хэнтий байдаг. 7 аймгийн ХХТөвөөр нийтдээ 200 гарам хүүхэд хамрагдаж, үйлчилгээ авч байна.</li> <li>2. Ногоон гархан урлан/Оюуны ялгаатай чадвартай залуусыг хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, Job coach-ийн эрхзүйн орчинг бий болгохын төлөө ажиллаж байна. / САОРИ 5 машиныг Японоос худалдан авч оюуны ялгаатай чадвартай залуус ажил хөдөлмөр эрхэлж чаддгийг олон нийтэд, ажил олгогчид харуулж байна. Гар урлалаар голчлон бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулдаг. Хэдийгээр борлуулалт муу ч гэсэн бид залуусаар бүтээгдэхүүн үйлдвэрлүүлж, үзэсгэлэн худалдаанд оролцож, өөрсдөө зохион байгуулж амьдралыг нь баяр жаргалтай болгохын төлөө Үндэсний хэмжээний бодлогод нөлөөлж ажиллаж байна. Ногоон гархан урлан нь УБ, Орхон аймагт хэдий нь 3-5 жил болсон, 15 орчим залуусыг ажлын байраар түр болон байнга хангаж байна. Дорнод, Ховд аймгуудад үүсгэл санаачлага бий болж урлан байгуулахаар ажиллаж байна. Зөвлөх эцэг эхийн хөтөлбөр / Хуулиар олгосон боломжийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр эдэлдэг болгоход эцэг эхчүүдийг чадавхижуулан, эрх мэдэлжүүлдэг. Одоогоор 5 эрх зүйн хөтөч /Паралегал/, 50 зөвлөх эцэг эхчүүдээр дамжуулан үндэсний хэмжээнд эцэг эхчүүддээ эрхзүйн анхан шатны зөвлөгөө өгч, тулгарсан асуудлыг эрхзүйн хүрээнд шийдвэрлэхэд тусалж ажиллаж байна./ 2021 онд цахимаар ЗЭЭХөтөлбөрийг бүтэн жилийн туршид хэрэгжүүлж 21 аймаг, 8 дүүргийн 100 хүнийг хамруулж хүний эрх, хүний ялгаатай байдал, ялгаварлан гадуурхалт, бага насны хүүхдийн хөгжил, эрт үеийн оролцоо, төрийн үйлчилгээг сайжруулахад эцэг эхийн оролцоо гм агуулгаар цахим сургалт, мэдээллийг Бямба гараг бүрт өгч байлаа. Хууль эрх зүйг судалж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангуулахад эрхзүйн зөвлөгөөг эцэг эхэд өгч сургахад ЗЭЭХөтөлбөр үндсэн зорилгоо чиглүүлэн 17 удаагийн кейс хэлэлцүүлгийг зохион байгуулж Хүүхдийн эрхийн зөрчлийн үед хэрхэн эрхзүйн шинжилгээ хийж, зөвлөн, зуучилж ажиллах арга барилд Зөвлөхүүдийг дагалдуулан сургасан юм. Одоо 50 Зөвлөх эцэг эх бэлтгэгдэж цаашид өөр өөрийн орон нутагт ХБХийн эцэг эхчүүдэд эрхээ шаардах, төрийн үйлчилгээг чанартай болгоход эрхзүйн мэдлэгтэйгээр оролцоход тусалж сайн дураараа ажиллах болно. 2021 онд Сурч боловсрох эрхээ эдлэхэд эцэг эхэд зориулсан хуулийн гарын авлагыг боловсруулан гаргалаа.</li> </ol>



	<p>3. Нөлөөллийн хөтөлбөр / Үндэсний болон орон нутгийн түвшинд бодлогод нөлөөлж ажиллаж байна. Хууль, дүрэм, журам боловсруулах үйл ажиллагаанд эцэг эхчүүдээ төлөөлөн оролцож, орон нутагт мониторинг хийх замаар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрөөс чанартай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхэд нөлөөлж ажилладаг./ Боловсролын багц хуулийн төсөлд, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн төсөлд, Саадгүй байдал хүртээмжийн тухай шинэ хуулиудад саналаа хүргүүлэн ажлын хэсэгт ажиллаж байна. Энэ нь Эцэг эхчүүдийн хууль боловсруулах үйл ажиллагаанд ХБХийнхээ эрхийг хангуулахаар оролцож буй явдал юм. Мөн олон нийтийн хандлагыг өөрчлөх, эерэг болгохын тулд Хаалгаа Нэе аяныг зохион байгуулж ажиллалаа. ХҮҮХЭД БҮХЭН ЖАРГАЛТАЙ БАЙГ</p>
<p>Япон болон олон улсын хамтын ажиллагаа</p>	<p>НҮБ-ын Хүний эрхийн хороодод Хүүхдийн болон ХБХүний тайланг хүргүүлж, хамтын ажиллагаатай. Японы 3 ТББ-тай хамтран ажилладаг. Палетте ТББ Токио, Empowerment Okinawa NPO, NPO Saori Hiroba Network АНУ-ын TASH ТББтай хамтран ажилладаг. Inclusion International ОУБ-ын Гишүүн ЖАЙКА-тай хамтын ажиллагаа 2018 онд С.Сэлэнгэ Окинавад ЖАЙКА-гийн хөтөлбөрт хамрагдсан. 2016-2020 онд ЖАЙКА-гийн Сайн дурын 2 ажилтанг Холбооныхоо хүүхэд хөгжлийн төвд ажиллуулсан. Коронагийн хөл хориогоор 2 дахь хүн бүрэн ажиллаж чадаагүй буцсан.</p>
<p>ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр</p>	<p>2016-2019 онд Японы Нинжин сангийн хэрэгжүүлсэн төсөл, ХБХЭЭХолбооны 2 төвд ХБХүүхдүүдэд эцэг эхээр дамжуулан хөгжлийн болон сэргээн засах үйлчилгээг хүргэх төсөл</p>



## Лантуун дохио

Байгууллагын нэр	Лантуун дохио ТББ
Байгуулагдсан он	2013 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, 23 дугаар хороо, Баатархайрхан гудамж, 26 хэсэг, 1545 тоот
Утасны дугаар	77076996, 94222888, 88084470
E-mail	info.mng@lantuundohio.org
URL/Facebook	www.facebook.com/lantuundohio, www.facebook.com/idshidiinoron
Төлөөлөгчийн нэр	У.Ганбаяр, О.Ундраа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>"Лантуун дохио" нь 2013 оноос эхлэн хүний наймаа, хүүхэд эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг чиглэлтэй үйл ажиллагаа явуулах, холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, шат дараалсан сургалтын хөтөлбөр боловсруулан хөгжүүлж, дэлхий нийтээр хэрэглэж болохуйц хүчирхийллийн эсрэг олон нийтийг хамарсан үйл ажиллагааг эх орондоо хэрэгжүүлэх зорилготой ашгийн төлөө бус, НҮБ-ын "Зөвлөлдөх эрх" бүхий статустай, нийгэмд үйлчилдэг ТББ юм.</p> <p>Бид 2017 оноос 2020 онуудад "Ид шидийн орон 1" болон "Ид шидийн орон 2" Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвүүдийг Улаанбаатар хотын хамгийн их хүн амтай, гэмт хэргийн гаралт өндөртэй Сонгинохайрхан болон Баянзүрх дүүргийн алслагдсан гэр хорооллын бүсэд 100 хувь олон нийтийн хандив, дэмжлэгээр бүтээн байгуулсан билээ.</p> <p>Энэхүү төвүүд маань хүчирхийллийн хохирогч хүүхдэд "хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ" үзүүлэх төдийгүй гэр хорооллын алслагдсан хэсэгт амьдарч буй хүүхдүүдэд тэгш боломж олгох үүднээс сургуулийн өмнөх боловсрол олгох, түүнчлэн номын сан, тоглоомын талбай, ногоон байгууламж, нийт 25 төрлийн сургалтыг үнэ төлбөргүй явуулдаг онцлогтой.</p> <p>Дээр дурдсан бүхий л үйл ажиллагаанд АНУ дахь "Лантуун дохио" ТББ-ын хамт олон болон АНУ, Австрали, Австри, Бельги, Английн Манчестир, Солонгос, Япон зэрэг гадаадын оронд ажиллаж, амьдарч буй "ИД ШИДТЭЙ АХ, ЭГЧ" нарын байнгын, тогтмол дэмжлэг, мөн 300 гаруй сайн дурын гишүүдийн маань нөр их сэтгэл, хичээл зүтгэл хамгийн чухал хэсэг байдаг.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Япон улсын болон олон улсын бусад байгууллагатай хамтын ажиллагаагүй байна.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Одоогийн байдлаар хамтарсан төсөл, хөтөлбөр байхгүй.





## Хөөрхөн зүрх

Байгууллагын нэр	Хөөрхөн зүрх
Байгуулагдсан он	2012 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө, 1-р хороо, 58-байр Ү-4 тоот
Утасны дугаар	70159688, 95959688
E-mail	huurhunzurh@gmail.com ,oyundari@btifulhearts.org
URL/Facebook	<a href="https://www.facebook.com/btifulhearts">https://www.facebook.com/btifulhearts</a>
Төлөөлөгчийн нэр	Ерөнхий зохицуулагч Б.Оюундарь
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>“Хөөрхөн Зүрх” ТББ нь Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоохын төлөө 2012 оноос эхлэн ажиллаж буй төрийн бус, шашин болон нам, ашгийн бус байгууллага юм. Бидний алсын хараа эрүүл аюулгүй нийгмийн төлөө бодлогод нөлөөлөх, олон нийтийг хүний эрх, жендэрийн тэгш эрх, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар иргэд, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, хандлагад нөлөө үзүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ухуулан сурталчлах ажиллагааг эерэг аргаар нийгмийн хандлагыг өөрчлөх зорилго дор нэгдсэн салбар бүрийн залуусын нэгдэл юм.</p> <p>“Хөөрхөн Зүрх” ТББ нь дараах 4 үндсэн хөтөлбөртэй:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ <b>НӨЛӨӨЛӨЛ</b> - Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хохоригч, даван туулагчдыг хамгаалах, хүний эрхэд суурилсан хууль эрхзүйн тогтолцоог бий болгоход бодлогын нөлөөлөл хийх.</li> <li>✓ <b>ҮЙЛЧИЛГЭЭ</b> - Бэлгийн хүчирхийллийн даван туулагч хүүхдүүдэд сэтгэл засал, нөхөн сэргээх нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх.</li> <li>✓ <b>УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ</b> – Хүүхэд, өсвөр насны охид, хөвгүүдийг жендэрт суурилсан хүчирхийллээс үүдэлтэй аливаа болзошгүй бэрхшээлээс урьдчилан сэргийлэхэд ухуулан сурталчлах.</li> <li>✓ <b>ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ</b> – Хохирогч, даван туулагчдын эрхийг хамгаалан ажилладаг салбар бүрийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг туршлагыг нэмэгдүүлж, чадавхыг бэхжүүлэх.</li> </ul> <p>Жил тутамд тогтмол зохион байгуулагддаг томоохон кампанит ажил, үйл ажиллагаанууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ “НЭГ ТЭРБУМААРАА ТЭМЦЬЕ-ONE BILLION RISING” Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох Олон улсын эсэргүүцлийн кампанит ажил.</li> <li>✓ “Тавдугаар сар - Бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” Үндэсний хэмжээний кампанит ажил</li> <li>✓ “PEER CONSULTATION” даван туулагчидтай ажилладаг мэргэжилтнүүдийн сар тутмын уулзалт, арга хэмжээ</li> <li>✓ “Олон улсын охидын эрхийн өдөр”-ийг тохиолдуулан урьдчилан сэргийлэх кампанит ажил.</li> <li>✓ “16 хоногийн аян” Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх кампанит ажил</li> <li>✓ Мэргэжилтнүүдийн чадавх бэхжүүлэх жил тутмын мэргэшүүлэх 3 өдрийн сургалт</li> <li>✓ Өсвөр насны охид, хөвгүүдийг жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалтууд.</li> </ul> <p>Байгууллагын бүтэц: “Хөөрхөн Зүрх” ТББ нь Удирдах зөвлөлийн 7 гишүүнтэй (57% нь эмэгтэй 43% нь эрэгтэй). Нийт 28 үндсэн гишүүдтэй. Ажлын албанд бүтэн цагийн 8 ажилтантай/100% эмэгтэй. (Нийгмийн ажилан, Сэтгэлзүйч, Сэтгүүлч мэргэжилтэй)</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>✓ Японы хүүхдийг ивээх сантай хамран ажилладаг (Монголын).</li> <li>✓ Хүүхдийн эрхийн эвсэлийн гишүүн (Ази номхон далайн). (2018-с хойш)</li> <li>✓ Нэг тэрбумаараа тэмцье олон улсын хөдөлгөөний гишүүн, Монгол улс дахь зохицуулагч. (2013-с хойш)</li> <li>✓ FRIDA залуу эмэгтэйчүүдийн феминист ОУБ-ын үр шим хүртэгч (2017-2022)</li> <li>✓ APWLD ОУБ-ын гишүүн.</li> <li>✓ With and For Girls 2017 оны шагнал хүртэгч</li> </ul>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





## BEAUTIFUL HEARTS' ACTIVITY | IN 2020



/btifulhearts

976-70159688



Annual report 2020

**"Beautiful Hearts" NGO**  
*Together we can end child sexual abuse!*

I promise,



European Union  
 Swiss development agency  
 51,353\$



"Time's up for sexual violence against children" project  
 The project goal is Mongolian CSOs have better capacities to contribute to the prevention of sexual violence against most vulnerable children and strengthen protection measures to safeguard their human rights through stronger skills and linkages co-implementing by World Vision Mongolia.

One Billion Rising 2020 - Our Voice  
 On International Women's Day, 8th of March for ending all forms of gender-based violence and raising public awareness, attention, and prevention of recognizing the causes and effects of gender-based violence and victim blaming at national level and as well as regional and international level in solidarity.



Mongolian Women's Fund  
 Embassy of Canada  
 4,000\$

The Asia Foundation Mongolia  
 10,550\$



Information booklets and posters on Domestic Violence Legislation and Referral Services, support group meetings for women entrepreneurs  
 We have published production of a factual information booklet on domestic violence referral services, including access to justice and explanation of the DV Law.

Trauma Informed Service/PsychoSocial service  
 Each year we provide trauma-informed service to 33 victims/survivors of sexual violence.



Foundation Dufresne Et Guathier  
 9,900\$

FRIDA Young Feminist Fund  
 17,500\$



Strong Girls - Strong Nation is an interactive smart device application and animation aimed at preventing child sexual abuse that we designed and had developed. The "Strong Girls" app and 2 animation is designed for ages 3 to 18 years and covers topics such as incest, safety at school and in public places.

School is not a hospital is an advocacy campaign to virginity tests for girls at secondary schools in Mongolia co-implemented by Princess center.



Canada Fund  
 7,000\$

Open society forum  
 7,800\$



Providing legal knowledge on the prevention of domestic violence  
 The aim is to provide local women with relevant legislation and necessary information on domestic violence as a paralegal.

**Япон улсад төвтэй Хүүхдийг ивээх сан ОУБ**

Байгууллагын нэр	Япон улсад төвтэй Хүүхдийг Ивээх Сан ОУБ
Байгуулагдсан он	2009 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв
Утасны дугаар	329365,329371
E-mail	mongolia.secretary@savethechildren.org
URL/Facebook	Save the children in Mongolia
Төлөөлөгчийн нэр	Лувсандоржийн Баян-Алтай
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Хүүхдийг Ивээх Сан нь Боловсрол, Хүүхэд Хамгаалал болон Хүүхдийн Эрхийн Засаглал, Хүүхдийн Ядуурлыг Бууруулах болон Хүмүүнлэгийн хөтөлбөр, эрүүл мэнд гэсэн чиглэлээр дараах төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлж байна.</p> <p>1.ТӨСЛИЙН НЭР: “МОНГОЛ УЛСАД ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ НЬ” Төслийн хугацаа: 2021.04 -2024.04 Төслийн зорилго, зорилт: Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүд, Өвөрхангай болон Ховд аймгийн сонгогдсон зорилтот сургуулиудын бага, дунд ангийн хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.</p> <p>2. ТӨСЛИЙН НЭР: ОРОН НУТГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ХУВЬ ХҮНИЙ УР ЧАДВАР, ЭНТРЕПРЕНЕРШИПИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ТӨСӨЛ: Төслийн хугацаа: 2019-2023 (4 жил) Төслийн зорилго, зорилт: Өсвөр үеийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох замаар сурлагын амжилтыг сайжруулж, цаашлаад хөдөлмөр эрхлэлтэд бэлдэхэд оршино. Төслийн үр дүнд хүрэхийн тулд сургуульд болон хөдөлмөрийн зах зээлд өндрөөр үнэлэгддэг хувь хүний ур чадваруудыг олгох сургуульд суурилсан, орон нутгийн залуучууд өсвөр үеийнхний оролцоотой хөтөлбөрийг нэвтрүүлэх.</p> <p>3. ТӨСЛИЙН НЭР: “АРДЧИЛЛЫН ТӨЛӨӨХ ШИНЭ ҮЕ” Төслийн хугацаа: 2020.03 -2022.02</p> <p>4. ТӨСЛИЙН НЭР: “ОХИДЫГ ХҮЧИРХИЙЛЭЛ МӨЛЖЛӨГӨӨС ХАМГААЛАХ НЬ” Төслийн хугацаа: 2021-2024 (3 жил) Төслийн зорилго, зорилт: Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн түвшин доогуур 5 дүүргийн 12-18 насны охидыг КОВИД-19 цар тахлын хүчин зүйлийн улмаас хүндэрсэн хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлээс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах</p> <p>5.ТӨСЛИЙН НЭР: “ДЭНАН” ТӨСӨЛ: Төслийн хугацаа: 2021 он Төслийн зорилго, зорилт: Орон нутгийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг дэмжих, чадавхыг дээшлүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах</p> <p>6. ТӨСЛИЙН НЭР: “МОНГОЛ УЛСАД ИЛ ТОД БАЙДАЛ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” БУЮУ MASAM II ТӨСӨЛ Төслийн хугацаа: 2021-2023 Төслийн зорилго, зорилт: Гол салбаруудад төсвийн хөрөнгийг илүү үр дүнтэй ашиглах замаар Монгол улсын 21 аймаг, Улаанбаатар хотод төрийн үйлчилгээг хүргэх, хөрөнгө оруулалтыг сайжруулахад чиглэсэн нийгмийн эгэх хариуцлагыг нэмэгдүүлэх чадавхийг бэхжүүлж, техникийн туслалцаагаар хангах</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Япон улсын гадаад явдлын яам болон Японы Нийгмийн Хөгжлийн Сан, ЖАЙКА ОУБ зэрэг Японы улсын доноруудтай хамтран ажиллаж байна.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	ТӨСЛИЙН НЭР: МОНГОЛ УЛСАД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ, 2018-2022 Ерөнхий зорилго: Монгол Улсад хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхийн тулд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгаалал болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаснаар хүүхэд бүр хамгаалагдах эрхээ эдэлнэ.





## Хүчирхийллийн эсрэг үндэсний төв

Байгууллагын нэр	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
Байгуулагдсан он	1995 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, 40-р байрны 03 тоот
Утасны дугаар	70119949
E-mail	mongolcav@gmail.com
URL/Facebook	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв ТББ / National Center Against Violence NGO
Төлөөлөгчийн нэр	Н.Арвинтэриа (захирал)
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд хууль эрх зүйн зөвлөгөө, сэтгэл зүйн зөвлөгөө, итгэлтэй утасны үйлчилгээ, түр хамгаалан байрлуулах үйлчилгээг шууд хүргэдэг.</p> <p>Байгуулагдсанаасаа хойш 26 жилийн турш тогтвортой ажиллаж, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн 22 мянга гаруй охид, эмэгтэйчүүдэд үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>ХЭҮТ нь үйлчилгээгээ ГБХТ тухай хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдийг чадавхижуулах, олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх болон бодлогын нөлөөлөлтэй хослуулан явуулдаг.</p> <p>2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх анхны хуулийг Монгол Улсад батлуулах нөлөөллийн үйл ажиллагаанд манлайлан оролцсон. Мөн уг хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор мониторинг хийж, 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Парламентаар батлуулж чадсан. Мөн Монгол Улсад анх удаа гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцуулж, Эрүүгийн хууль, Зөрчлийн хуульд тусгуулсан. Мөн бусад хуулиудад гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалахтай холбоотой зохицуулалтуудыг тусгуулж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн цогц орчныг бүрдүүлж чадсан.</p> <p>ХЭҮТ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд жил бүр хэсэгчилсэн мониторинг хийж, дүгнэлт, зөвлөмжийг төрийн эрх бүхий байгууллага, шийдвэр гаргагчдад хүргүүлдэг.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах” хөтөлбөрийн хүрээнд ХЭҮТ-ийн Баянхонгор аймаг дахь салбарт “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах үйлчилгээний байр”-ыг 2016 оны 10 дугаар сарын 8-ны өдөр ашиглалтад оруулсан. Уг байр өнөөг хүртэл тогтвортой ажиллаж байна.</p> <p>ХЭҮТ нь Дэлхийн хамгаалах байруудын сүлжээ, Азийн хамгаалах байруудын сүлжээ, Дэлхийн итгэлтэй утасны сүлжээ, FORUM ASIA, Олон улсын нийгмийн үйлчилгээний глобал сүлжээ (ISS), APWLD-ын гишүүн байгууллага юм.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Баянхонгор аймаг дахь гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн нээлтийн ажиллагаа 2016-10-08-ны өдөр



## Нар Сар Оюу

Байгууллагын нэр	Нар Сар Оюу
Байгуулагдсан он	2013 он
Хаяг	Архангай аймаг, Эрдэнэбулган сум
Утасны дугаар	96969644, 85156023
E-mail	nrentsendorj2@gmail.com, damba_avraa@yahoo.com
URL/Facebook	Avarzad Avraa, Рэнцэндорж Нарантуяа
Төлөөлөгчийн нэр	Д.Аварзад, Р.Нарантуяа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Нар Сар Оюу ТББ нь Иргэдийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалт, семинар, уулзалт ярилцлага зохион байгуулах үйл ажиллагааны үндсэн чиглэлтэйгээр ажиллаж байна. Тус байгууллага нь 5 гишүүнтэй. Архангай аймагт сургалт мэдээлэл, уулзалт зохион байгуулж шаардлагатай иргэдэд нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг.</p> <p>2018 оноос Архангай аймагт хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулан хамтран ажиллаж байна.</p> <p>2019 онд НХЯ-ны А/330 тоот тушаалаар Хүүхэд хамгааллын магдлан итгэмжлэгдсэн гэрчилгээ авсан. /зураг хавсаргав/</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллагын дэмжлэгтэйгээр “Шилжин суурьшигчдад бид туслана” төслийг 6 сарын хугацаатай хэрэгжүүлж шилжиж ирсэн игэдэд нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлж ажилласан.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Тус аймагт ЖАЙКА-гийн санхүүжилттэй “Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төсөл хэрэгждэг бөгөөд тус төслийн хүрээнд байгууллагын ажилтан “Хамтарсан багийг чадавхжуулах”, “Хүүхэд хүмүүжлийн зэрэг арга” – сургалтуудын үндэсний сургагч багшаар бэлтгэгдсэн. Архангай аймгийн Гэр бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газартай хамтран хүүхэд хамгааллын хамтарсан багийг чадавхжуулах сургалт, мэдээллийг хамтран зохион байгуулж байсан.



Хамтарсан багийг чадавхжуулж байгаа нь

Чадавхжуулах сургалтуудаас....

## Бор тагшны бодол


Байгууллагын нэр	Бор тагшны бодол
Байгуулагдсан он	2019 он
Хаяг	Архангай аймаг. Эрдэнэбулган сум I баг. Зая гэгээнтний гудамж 103, Тамир кино театрын байр 2 давхарт 02 тоот
Утасны дугаар	94339590, 99339590
E-mail	bor.tagsh@yahoo.com
URL/Facebook	Бор Тагшны Бодол
Төлөөлөгчийн нэр	А. Дөлгөөн – Хүний их эмч Ч. Уранцэцэг – Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагын ахмад ажилтан
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>“Бор Тагшны Бодол” НҮТББ нь нийгмийн анхдагч нэгж, хүний хөгжлийн суурь болох гэр бүл болон гэр бүлийн гишүүд, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн хөгжил, хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн хөгжлийн тогтвортой байдлыг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах замаар гэр бүлийн болоод нийгмийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах зорилготойгоор 2019 оны 12 сард байгуулагдан Архангай аймгийн Эрдэнэбулган суманд үйл ажиллагаагаа явуулдаг.</p> <p>Байгууллагын дотоод бүтцийн хувьд Удирдах зөвлөлийн зохион байгуулалттай бөгөөд дүрэм, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд удирдах зөвлөлөөс гарсан шийдвэр, жилийн ажлын төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх, өдөр тутмын ажил үүргийг гүйцэтгэдэг ба ажлын үр дүн, шийдвэрийн биелэлтийг удирдах зөвлөлдөө тайлагнан ажиллаж байна.</p> <p>Байгуулагдсанаас хойш дэлхий нийтийг хамтарсан Ковид-19 цар тахалтай байгаа хэдий ч үйл ажиллагаагаараа дамжуулан хүүхдийн эрхийг таниулах, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, эрүүл мэндээ хамгаалах дадал хэвшилд суралцах, гэр бүлийн хөгжлийг дэмжих, амьдрах ур чадвараа нэмэгдүүлэх мэдлэг, ойлголтыг сургалт, олон нийтийн үйл ажиллагааны хэлбэрүүдээр халдвар хамгааллын дэглэмээ баримтлан 938 хүүхэд, эцэг эх, гэр бүлд үйлчилгээ үзүүлсэн .</p> <p>Гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлэх, гэр бүлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Гэр өрөг” танин мэдэхүйн цэнгэлдэх хөлөгт тоглоомыг зохиож олны хүртээл болгосон ба Монгол улсын Оюуны өмчид бүртгүүлэн зохиогчийн эрх авсан. Энэхүү тоглоом нь иргэдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, харилцаа хандлагад нөлөөлөх арга зүйн чухал хэрэглэгдэхүүн болж байгаа онцлогтой.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Японы хүүхдийг ивээх сантай хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх асуудлаар 2019 оноос хойш хамтарч ажилласан.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	ЖАЙКА-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн 1,2 дахь шатны хэрэгжүүлэлтийн багтай хамтран ажилласан.






## Ирээдүйн нээлттэй цонх

Байгууллагын нэр	Ирээдүйн нээлттэй цонх
Байгуулагдсан он	2018 он
Хаяг	Баянгол дүүрэг, 13-р хороо, Дако бизнес төв, 802 тоот
Утасны дугаар	99878556
E-mail	openwindowfff@gmail.com,batkhisig@f-openwindow.mn
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	А. Батхишиг/тэргүүн/
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Ирээдүйн нээлттэй цонх (ИНЦ) нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага (НҮТББ)-ын үүсгэн санаачлагчид хүүхэд, залуус, гэр бүлийн хөгжил, хамгаалал, оролцоо чиглэлээр хорь гаруй жилийн ажилласан олон улсын хийгээд үндэсний туршлага дээрээ тулгуурлан 2018 оны 8 сард тус нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагыг байгуулсан.</p> <p>ИНЦ нь нотолгоонд суурилсан мэдлэг, судалгаа шинжилгээнд тулгуурлан хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжил, хамгаалал, оролцоог дэмжин, тэднийг эрхийг хамгаалах, чадавхжуулахад хувь нэмэр оруулах зорилготой.</p> <p>Тус байгууллага нь үйл ажиллагаандаа тэгш оролцоо, аюулгүй байдал, хүний эрх, ялгаатай байдлыг хүндэтгэх зарчмуудыг баримтална.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн хөгжил, оролцоо</li> <li>• Хүүхэд хамгаалал</li> <li>• Өсвөр үе, залуучуудын хөгжил оролцоо</li> <li>• Гэр бүлийн боловсрол, хөгжил</li> <li>• Зорилтот бүлгийн хүүхэд, залуусын хөгжил, хамгаалал</li> </ul> <p>ИНЦ, НҮББ-ын зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа гэдэгт хөгжлийн бэрхшээл, орлогын ядуурал, ялгаварлан гадуурхалд өртсөн бүлэг, гэр бүлийн гишүүдэд чиглэсэн үйл ажиллагаа хамаарна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>2018 он</p> <ul style="list-style-type: none"> <li>• ЯХИС-гийн захиалгаар хийгдсэн Хамтарсан багийн нийгмийн ажилтан нарт зориулсан гарын авлага боловсруулах зөвлөх үйлчилгээ</li> <li>• НҮБ-ын Хүүхдийн сан, БСШУЯ-ны захиалгаар хийсэн ЕБС дахь Хүүхэд хамгааллын бодлогын эх боловсруулах зөвлөх үйлчилгээ</li> </ul> <p>2019 он</p> <ul style="list-style-type: none"> <li>• АХБ-ны санхүүжилтээр хийсэн Түгээмэл хөгжил төв, Олон нийтийн архитектор ТББ-уудтай хамтран хийсэн Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах хэрэгцээний үнэлгээ</li> <li>• ЯХИС, ГБХЗХГ-ын зохион байгуулсан Өдөр тутмын хүмүүжлийн эерэг арга сургалтын үндэсний чиглүүлэгч сургалтын оролцогч, улмаар үндэсний чиглүүлэгчийн хувьд БЗД-ын 26 хорооны залуу эцэг эхчүүдэд зорилуан хийсэн найман цуврал хичээл</li> </ul> <p>2020 он</p> <ul style="list-style-type: none"> <li>• НҮБХС, ХНХЯ-ны Нийгмийн үйлчилгээний боловсон хүчинг чадавхижуулах төслийн хүрээнд хийгдсэн Хүүхэд хамгаалал дахь шууд практикийн стандартын төсөл, мэргэжлийн удирдлагын шатлалын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ</li> </ul> <p>2021 он</p> <ul style="list-style-type: none"> <li>• НҮБХС, ГБХЗХГ-ын захиалгаар 108 тусламжийн утасны зөвлөгчийн карт боловсруулах зөвлөх үйлчилгээ</li> <li>• ДЗОУБ-ын Дархан-Уул аймгийн хөтөлбөрийн захиалгаар хийсэн “Хорт зуршлаас сэргийлэх нь” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалт</li> <li>• НҮБХС, ХНХЯ-ны санхүүжилтээр Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх шинэчилсэн журмын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ</li> <li>• НҮБХС, ХНХЯ-ны санхүүжилтээр Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт ба шинэчилсэн найруулга, Нийгмийн ажилтны эрх зүйн байдлын тухай хуулийн анхны төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ</li> </ul>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	2019 он Японы Олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА-гийн санхүүжилтээр хэрэгжсэн Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь төслийн хүрээнд хийгдсэн Кейс менежментийн сургагч багш бэлтгэх сургалт



2021 оны 4 сард зохион байгуулсан ДЗМОУБ-ын Дархан-Уул аймгийн салбарын захиалгаар хийсэн “Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургагч багш бэлтгэх онлайн сургалтын үеэр



ЖАЙКА байгууллагын санхүүжилтээр ЯХИС-ын зохион байгуулсан Кейс менежментийн сургагч багш бэлтгэх сургалтын сургагч багш ИНЦ, ТББ-ын тэргүүн Др. А.Батхишиг



Нийслэлийн ГБХЗХГ-ын санхүүжилтээр Гэр бүлийн дэмжих туршилтын хөтөлбөрийн үнэлгээний үеэр гэр бүлийн гишүүд, гэр бүлийг дэмжин ажилладаг байгууллагын төлөөлөлтэй хийсэн уулзалтууд

## Эмэгтэй удирдагч сан

Байгууллагын нэр	Эмэгтэй удирдагч сан
Байгуулагдсан он	2001 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, UBH Center 7-718
Утасны дугаар	99099143
E-mail	womanleaderfound@gmail.com, bolormaa.mashlai@gmail.com
URL/Facebook	Эмэгтэй удирдагч сан (Women Leader Foundation NGOs)
Төлөөлөгчийн нэр	М.Болормаа / тэргүүн/
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>ЭУС нь нийгэмд ардчилал, шударга ёс, ил тод байдал, сайн засаглалыг хөгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн хүний эрхийн хамгаалахад хувь нэмрээ оруулахад оршино. Эмэгтэй удирдагч сан нь 2022-2024 оны стратегт дараах чиглэлд анхаарлаа хандуулан ажиллаж байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Жендэрийн үзэл баримтлал, жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд нөлөөлөх, мониторинг, үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах</li> <li>• Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах, мөн эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг залуу үед ойлгуулах, өвлүүлэхэд зэрэг болно.</li> <li>• Жендэрт суурилсан хүчирхийлэлийн эсрэг ялангуяа ажлын байрны бэлгийн дарамт, охид эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, гэгээрүүлэх, төр болон АННБ –уудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах</li> </ul> <p>Үйл ажиллагааны хэлбэр:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бодлогын нөлөөлөл хийх</li> <li>• Сургалт зохион байгуулах</li> <li>• Жендэрийн үнэлгээ хийж, зөвлөгөө өгөх</li> <li>• Тандалт судалгаа хийх</li> </ul> <p>Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хувьд Удирдах зөвлөлийн 9 гишүүнтэй, 2 зөвлөхтэй, өдөр тутмын үйл ажиллагаагаа зохион байгуулж ажилладаг ажлын албатай. 2 хүн ажилладаг.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Эмэгтэй удирдагч сан нь Монгол Улс дахь Азийн сан, Дэлхийн банк, Нээлттэй нийгэм форум, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Mama Cash, Global Women's fund, Canada fund болон Women's Asia Fund-ын дэмжлэгтэй жижиг төслүүдийг нийгэмд тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна. Information center for Women's Education in Japan-тай холбоотой улирал бүрийн сэтгүүл хүлээн авч хамтран ажилладаг байсан.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





## Өсвөр үеийнхний хөгжлийн төв

Байгууллагын нэр	Өсвөр үеийнхний хөгжлийн төв
Байгуулагдсан он	2005 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, Ногоон Урлан хотхон 73-1 байр
Утасны дугаар	324333, 9902-8922
E-mail	enkhtuya@adc.org.mn
URL/Facebook	Өсвөр Үеийнхний Хөгжлийн Төв/ADC
Төлөөлөгчийн нэр	Гүйцэтгэх захирал Даржаагийн Энхтуяа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Зорилго:</p> <p>Хүүхэд өсвөр үеийнхний (12-22 насны) хөгжил, хамгаалал, нийгмийн оролцооны чиглэлээр гадаад дотоодын ТББ-д, ОУ-ын байгууллагууд, Төрийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, шинэлэг санаа төсөл хөтөлбөрүүдийг орон нутгийн бүлгүүд, сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулж, үр дүнтэй хэрэгжүүлэхэд бидний зорилго оршдог.</p> <p>Үйл ажиллагааны чиглэлүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрсдэлт бүлгийн хүүхэд өсвөр үеийнхний эрх, үүрэг, оролцоо, амьдрах ухааны мэдлэг чадварыг нэмэгдүүлэх төрөл бүрийн сургалтын арга зүйг боловсруулж, хэрэгжүүлэн, тэднийг нийгэмд бие даасан зөв хүн болж төлөвшихөд туслах</li> <li>• Хүүхэд залуучуудын ирээдүйн мэргэжил сонголтод туслах зөвлөгөө мэдээлэл өгөх</li> <li>• Хүүхэд гэр бүзлтэй ажиллах сонирхолтой орон нутгийн сургагчид, сайн дурынхныг дэмжиж, чадавхжуулан тэдний оролцоог нэмэгдүүлэх</li> <li>• Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсоох, хүний наймаа бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах</li> </ul> <p>Бидний хамтын үйл ажиллагаа:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Монголын сайн дурынхны гишүүн байгууллага, 2005 оноос</li> <li>• Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Үндэсний сүлжээний гишүүн байгууллага, 2008 оноос</li> <li>• Бүх нийт боловсролын төлөө Үндэсний эвслийн удирдах зөвлөлийн гишүүн байгууллага, 2005 оноос</li> <li>• Хүний наймаатай тэмцэх Төрийн бус байгууллагуудын үндэсний сүлжээний гишүүн, 2008 оноос</li> <li>• Хүүхдийн эрхийн форумын гишүүн, 2019 оноос</li> </ul>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• ECPAT - / End Child Prostitution Child Pornography and Trafficking of Children for Sexual Purposes/</li> <li>• Хүүхдийг бэлгийн бүх төрлийн мөлжлөг, хүний наймаанаас хамгаалах Олон улсын сүлжээ байгууллагын гишүүн, Монгол дахь зохицуулагч байгууллагаар 2005 оноос эхлэн ажиллаж байна.</li> <li>• 2014-2020 онд Олон Улсын шилжилт хөдөлгөөний байгууллага/ IOM – тай хамтран Монгол улсын дотоодын шилжилт хөдөлгөөнд орсон гэр бүл хүүхэд залуучуудын эрхийг хамгаалах, мэдлэг мэдээлэл түгээх, Орон нутгийн Засаг захиргааны байгууллага, хүн амын бүлгүүдтэй хамтран ажиллах төслүүдийг хэрэгжүүлсэн.</li> <li>• 2012-2020 онд Канадын Дүффресе Готтерийн сангийн санхүүжилтээр Өсвөр насны эмзэг бүлгийн охидыг бэлгийн мөлжлөг хүний наймаанаас хамгаалах “Мөрөөдлийн түлхүүр” төслийг хэрэгжүүлж, жил бүр 25-30 охидыг эрсдлээс хамгаалж, ирээдүйн зөв амьдралд бэлтгэх төслийг амжилттай хэрэгжүүлж ирсэн.</li> </ul>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	ЖАЙКА-тай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэггүй.







### Эмэгтэйчүүд хүүхэд хөгжил төв

Байгууллагын нэр	Эмэгтэйчүүд хүүхэд хөгжил төв
Байгуулагдсан он	2003 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг ,2-р хороо, их тойруу, 15,1 Ренталон, 422 б тоот
Утасны дугаар	94443347
E-mail	wcdc.mn@gmail.com
URL/Facebook	<a href="https://www.facebook.com/wcdc.mn">https://www.facebook.com/wcdc.mn</a>
Төлөөлөгчийн нэр	Бүрэнжаргал
Үйл ажиллагааны товч танилцуулга	Өрх толгойлсон, амжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой эмэгтэйчүүд тэдний үр хүүхдүүд болон өнчин хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих, амьдрах ухаанд сургах, сургалт зохион байгуулах.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийг 2012 онд хэрэгжүүлсэн
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй

## Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо

Байгууллагын нэр	Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо
Байгуулагдсан он	1992 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 2/1
Утасны дугаар	99115479, 99272868, 322212
E-mail	Mwla1992@gmail.com, badraadolgor@gmail.com
URL/Facebook	Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо
Төлөөлөгчийн нэр	Бадраагийн Долгор МХЭХ-ны Тэргүүн
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо нь хуульч мэргэжлийн эмэгтэйчүүдийг нэгтгэсэн, бүх аймаг, дүүргүүдэд салбартай, гишүүнчлэлтэй, нийгэмд үйлчилдэг, төвийг сахьсан ТББ бөгөөд энэ онд 30 жилийн ойтойгоо золгож байна. Тэргүүн Б.Долгор, Дэд тэргүүн Д.Дүгэржав, Гүйцэтгэх Захирал П.Цэцгээ, Удирдах зөвлөл 19 гишүүн, Хяналтын зөвлөл 3 гишүүний удирдах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.</p> <p>Монгол Улсад эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, жендэрийн тэгш байдлыг хангах, иргэдийн эрх зүйн ухамсрыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, эрх зүйн боловсрол олгох, бодлогод нөлөөлөх, судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах чиглэлээр ажиллаж ирэв. Үүнээс, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төслийг боловсруулах, Иргэний, Гэр бүлийн, Хөдөлмөрийн зэрэг хуулиудад өөрчлөлт оруулах, хүний эрх, жендэр, авлигатай тэмцэх чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулах, хууль, бодлогын хэрэгжилтэд судалгаа хийх, жендэрийн дүн шинжилгээ хийх, байгаль хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг чиглэлийн үйл ажиллагааг товч дурдаж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Холбоо байгуулагдсан 1992 ондоо анхлан Япон улсын хуульч эмэгтэйчүүдийг эх орондоо урьж ирүүлэн, олон улсын хамтын ажиллагаа эхлүүлсэндээ бид ямагт бахархдаг. Энэ хүрээнд манай хуульч эмэгтэйчүүд 1994 онд Япон улсад танилцах аялал зохион байгуулж, мэргэжлийн байгууллагуудын туршлага судалж, холбоо тогтоосон юм. Мөн нэг ажилтан Япон улсад магистрт суралцсан. МХЭХ Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбооны гишүүн ба БНСУ, Тайваны хуульч эмэгтэйчүүдийн холбоотой эгч дүүсийн харилцаатай. Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлж ирснээс жишээ дурдвал, Дэлхийн Эмэгтэйчүүдийн сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүн амын сан, Европын холбоо, Олон улсын хөдөлмөрийн байгууллага /ILO/, Дэлхийн банк/ WB/, Азийн хөгжлийн банк /ADB/, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг /USAID/, Австралийн Олон улсын хөгжлийн агентлаг /AusAID/, Чехийн хамтын ажиллагааны агентлаг, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага /IDLO/, Соросын сан, Канад сан, АНУ-ын Азийн сан, Чехийн Пипл ин нийд /People in need/, МерсиКор Олон улсын байгууллага /MercyCorps/, Элчин сайдын яамд зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, жил тутамд 1-2 төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ирэв.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй

## Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан

Байгууллагын нэр	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан
Байгуулагдсан он	1992 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг ,8 дугаар хороо, GB Төв 3 давхар 302 тоот
Утасны дугаар	77007999,99992552,95099699
E-mail	info@leos.mn
URL/Facebook	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан
Төлөөлөгчийн нэр	Байгууллагын Тэргүүн Ц.Бүжидмаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<ul style="list-style-type: none"> <li>• Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан 1992 онд байгуулагдсан 21 аймагт салбар зөвлөлтэй үндэсний хэмжээний ТББ юм.</li> <li>• Монгол Улсад хүйсийн тэгш байдлыг хангах, нийгмийн бүхий л салбарт эмэгтэйчүүд мэдлэг чадвар, туршлагаа бүрэн дайчлан оролцох нийгмийн шударга тогтолцоог бүрдүүлэхэд гишүүдээрээ дамжуулан хувь нэмрээ оруулах нь манай байгууллагын эрхэм зорилго байсаар ирсэн.</li> <li>• Эмэгтэйчүүдийн манлайлал, Улс төрийн оролцоо, Сонгогчийн боловсролын чиглэлээр ажилладаг хүний эрх, эрх чөлөө, нийгмийн тэгш байдлыг хангах, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг.</li> </ul>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• 1994 онд Японд болсон Зүүн Азийн Эмэгтэйчүүдийн анхдугаар чуулга уулзалтанд ЛЭОС-ийн 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Монгол Улсыг төлөөлөн оролцож байсан.</li> <li>• 2002 онд Японы Сага мужийн Сага хотод болсон Азийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтанд Монгол Улсын эмэгтэйчүүдийн ТББ-уудыг төлөөлж ЛЭОС-оос 2 төлөөлөгч оролцов.</li> </ul> <p>Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн томоохон хөтөлбөрүүдийг дурьдвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2013-2015 онд НҮБ-ын эмэгтэйчүүд, жендэрийн тэгш байдлын сангийн дэмжлэгтэйгээр “Үндэсний хөгжилд эмэгтэйчүүдийн манлайлал” хөтөлбөр</li> <li>• 2016-2019 онд Канадын Засгийн газар, Азийн сангийн дэмжлэгээр “Авлигагүй нийгмийн төлөөх иргэдийн хяналт” хөтөлбөр</li> <li>• 2020 онд АНУ-ын Хөгжлийн агентлаг, БНОУХ-ийн тэтгэлгээр “Залуучууд эмэгтэйчүүдийн улс төр, сонгуулийн оролцоог бэхжүүлэх нь” төсөл</li> <li>• 2020-2022 онд НҮБХХ-ийн дэмжлэгээр Монгол Улсын Төрийн Албаны Зөвлөлөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх” төслийн хүрээнд “Төрийн албанд жендерийн тэгш байдлыг хангах нь” төсөлүүдийг амжилттай хэрэгжүүлсэн.</li> </ul>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





2019 он. Эмэгтэйчүүд Авлигагүй  
нийгмийн төлөө чуулган



2016 онд зохион байгуулсан  
“Эмэгтэйчүүд энхийн төлөө” чуулган



2021 онд хэрэгжүүлж буй Төрийн албан  
хаагч эмэгтэйчүүдийн манлайллын  
хөтөлбөр

**Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо**

Байгууллагын нэр	Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо
Байгуулагдсан он	2014 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө -35, UBH center, 7 давхарт 701 тоот
Утасны дугаар	70137083, 88683128
E-mail	Mwesf1@gmail.com
URL/Facebook	<a href="http://www.facebook.com/Монголын-Эмэгтэйчүүдийн-Хөдөлмөрийг-Дэмжих-Холбоо">www.facebook.com/Монголын-Эмэгтэйчүүдийн-Хөдөлмөрийг-Дэмжих-Холбоо</a>
Төлөөлөгчийн нэр	Ш.Ариунаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Монголын Эмэгтэйчүүдийн Хөдөлмөрийг Дэмжих Холбоо нь 2014 онд байгуулагдсан, охид эмэгтэйчүүд нь ажил хөдөлмөр эрхэлж, өөрийн орлоготой байхын хирээр аливаа хүчирхийлэл дарамтаас ангид байж, улс төр, нийгэм соёл, эдийн засгийн эрхээ бүрэн эдлэх боломжтой хэмээх үзэл санаан дээр сайн дураар нэгдсэн, ашгийн төлөө бус, улс төрийн нам бус, төрийн бус байгууллага билээ.</p> <p>Бид охид, эмэгтэйчүүдийн чадавхижуулах болон тэдний хөдөлмөрлөх, ждийн засгийн оролцоог нэмэгдүүлэх шийдвэр гаргагч нарт нөлөөлөх чиглэлүүдээр сургалт, судалгаа, нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг, Өвөрхангай болон Хөвсгөл аймагт салбартаж ажиллаж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



# MONGOLIAN WOMEN'S EMPLOYMENT SUPPORT FEDERATION

NON PROFIT, NON POLITICAL PARTY, NON GOVERNMENT ORGANIZATION

## BRIEF INTRODUCTION

### Our beliefs:

Girls and women can be free from violence and enjoy social, cultural, political and economic rights as long as they can work and earn their own income.

### Our mission:

Promote Mongolian women's employment and uphold economic benefits

### The principle:

Implement the principle of corporate governance. Open and transparent. Participation is ensured and decided by majority vote. Based on voluntary membership.

## GENERAL INFO ABOUT OUR ACTION

in 2014:

Five women were created on the initiative to work for the realization of women's labor rights.

A report on the subject of "Discrimination" was prepared in the Human Rights Status Report to the UN Human Rights Committee, supported by the Open Society Forum.

Nine delegates participated in the Global Summit of Women in Paris, France.

In 2015:

We organized the National Summit on Employment and Women's Rights, outlining the current need for women to have a child by raising children.

Women have also been offered suggestions on labor law and the Family Law, which are being amended by state policy to address this need.

Workshop on Sexual Abuse of the Workplace (IAF) has begun.

In 2016:

With the support of MONES, we continued the training and awareness-raising programs for citizens, students. Advisory work is done on the Open Government Partnership plan with the support of the Asian Development Bank. We lead policy awareness project about "The impact of the 5 package law reforms" with the support of the Open Society Forum.

11 delegates participated in the Global Summit of Women in Tokyo, Japan.



We organized the Employment and Women's Rights Forum was held at the Government House in March 2015 and was attended by more than 800 women.



Each season we organized "Early bird" meeting and discussion women's issues with members.



Every year we participate and co-organized international Human Rights day to promote women's labor rights.

We created some Recommendations on how to prevent sexual harassment at work for the public.



We have been attending the Global-Women's Summit since 2014. It is a travel program aimed at learning from the best women in the world and developing your business.





**Манай гэр нийгэмлэг ТББ “Миний гэр” хүүхдийн асрамжийн газар**

Байгууллагын нэр	Манай гэр нийгэмлэг ТББ “Миний гэр” хүүхдийн асрамжийн газар
Байгуулагдсан он	1998 он
Хаяг	Баянзүрх Дүүрэг, 26-р хороо, Их Монгол хороолол 901-р байр 1 тоот
Утасны дугаар	91913482 , 90903482
E-mail	Enhtsetseg972@yahoo.com
URL/Facebook	Enhtsetseg Aaya Taij
Төлөөлөгчийн нэр	Намжил Гаамаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	Хүүхдийн арсамж халамжийн үйл ажиллагаа явуулдаг.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Анх 1998 оноос эхлэн Япон улсын иргэн, Токиогийн Их Сургуулийн багш Аратамэ-Кэн нь Манай гэр бүл Нийгэмлэг ТББ-н тэргүүн Г.Энхцэцэг нар нийгэм дэх эмзэг бүлгийн хагас өнчин, орон гэрээсээ дайжсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн талаар 5 жилийн хугацаанд судалгаа явуулж 14 өрхийн 18 хүүхэд, 10 өрх толгойлсон эмэгтэйчүүдийн гэр бүлтэй хамтарч тэдэнд тусламж дэмжлэг үзүүлсээр ирсэн. 2003 оноос эхлэн 1-3 насны 8 хүүхдийг Улаанбаатар хотын ХХҮГ-н захирамж тусгай зөвшөөрлийн дагуу 24 цагаар 4 ажилтантай / Гэр Ээж / халамжийн төв нээн ажиллуулсан. Одоогоор нийт 1-гээс 21 насны нийт 42 хүүхэд асруулж байна.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



Б.Батдорж -г Цэргийн албанаас халагдахад нь НОСК-с 1 өрөө байрны батламжийг гардуулж өгөв.

Мөн М.Батжаргал нь МХН Цогц чадамж академид Албан хэрэг хөтлөлт, Нарийн бичиг мэргэжлээр амжилттай төгссөн. 2021 оны 10 сард Япон улсын Сайтама хот дахь EINKOKU сургуульд суралцахаар болсон.



Амьдрах ухаанд бэлтгэгдэн Ногоон тарьж, гурил бүтээгдэхүүнээр талх нарийн боов хийж сурсан.



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо 26-р байр 16 тоот

БЗ дүүргийн 26-р хороо, Их Монгол хороолол, 901байр -1тоот

Утас: 91913482

И-мэйл: enhtsetseg972@yahoo.com



## МАНАЙ ГЭР Асрамжийн газар

### БИДНИЙ ЗОРИЛГО

Манай хамт олон хүүхдийг гэрийн нөхцөлд таатай, тайван, аюулгүй, өвчингүй, дарамт шахалтгүй орчинд асарч, боловсрол эзэмшүүлж, чөлөөт цагийг нь зөв таатай өнгөрүүлж, авьяас чадварыг нь хөгжүүлж, амьдрах ухаанд бэлтгэнэ.



### Манай гэр 1.2

#### Асрамжийн газрын үйл ажиллагааны товч танилцуулга

Анх 1998 оноос эхлэн Япон улсын иргэн, Токиогийн их сургуулийн Багш Аратамэ – Кэн манай гэр бүл Нийгэмлэг ТББ-н тэргүүн Г.Энхцэцэг нар нийгэм дэх эмзэг бүлгийн хагас, бүтэн өнчин, орон гэрээсээ дайжсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн талаар 5 жилийн хугацаанд судалгаа явуулж 14 өрхийн 18 хүүхэд, 10 өрх толгойлсон эмэгтэйчүүдийн гэр бүлтэй хамтарч тэдэнд тусламж дэмжлэг үзүүлж ирсэн юм.

1. 2003 оноос эхлэн 1-3 насны 8 хүүхдийг Улаанбаатар хотын ХХҮГ-ын захирамж тусгай зөвшөөрлийн дагуу 24 цагаар 4 ажилтантай / Гэр ээж/ халамжийн төв нээн ажиллуулсан.

2. 2003-с эхлэн 1-16 насны 86 хүүхдийг түр байрлуулах, эрүүлжүүлэх, сургууль цэцэрлэгт хамруулах, орон гэрт нь буцаах, төрөл саданг нь олж өгөх ажлыг тасралтгүй явуулж эхэллээ.



21 дарь эхийн дуулалт бүжиг



21 цамын бүжиг



3. "Дуугаар хөлөглөсөн ирээдүй" урлагийн их наадамд оролцож мөнгө хүрэл медаль авч үргэлжлүүлэн Монголын анхны хүүхдийн хамтлаг Бөөгийн бүжиг, 21 цамын бүжиг, 10 хангал 21 дарь эх зэрэг үндэсний дуулалт бүжгийг дэглэн олны хүртээл болгосон.

4. Хүүхдүүдийг уран хатгамал, уран холбоо, наамал шигтгээ, хувцас, эсгүүр оёж, бүтээхийг зааж сургаж амьдралд бэлтгэн, урлаж бүтээхийн ач тусыг заан сурсан. Хүүхдүүдийн урласан бүтээлээр 2 удаагийн хүүхдийн үзэсгэлэн гаргасан.



5. Одоогийн байдлаар 5 – 19 насны 25 хүүхдийг БЗД-н 26-р хороо Их Монгол хорооллын арын орц, 1 тоотод, 19- 21 насны 10 хүүхдийг БЗД-н 1-р хороо 26 байрны 16 тоотод 2 салбартайгаар асрамж халамжийн үйл ажиллагаа явуулж байна.

6. 2015 оноос эхлэн хүүхдүүдэд байгаль орчиноо хайрлах, ургамал ногоогоо хайрлах, идэж буй ногоогоо ургуулж, тарьж сургах ажлын хүрээнд хүлэмж, ногоон талбайг байгуулан хүүхдүүдийг ногоо тарих ухаанд суралцуулан, үргэлжилсээр байна.

7. Түшиг, 22-р цэцэрлэгт СӨБ боловсрол, 2, 133-р сургуульд тус тус хүүхдүүд боловсрол эзэмшиж байгаа бол Хамаг Монгол МСҮТ, Эрдэнэ Сумын МСҮТ, Донбоско МСҮТ, Баянчандмань МСҮТ-г нийт 8 хүүхэд төгсөж мэргэжил эзэмшин, мэргэжлээ дээшлүүлэхээр Эко Ази Дээд сургуульд 3 хүүхэд, Сити Их Сургуульд 2 хүүхэд тус тус бакалаврын зэрэг эзэмшин төгссөн.

8. М.Батжаргал, Б.Амгаланбаатар нар нь 2019 – 2020 оны хооронд Япон улс руу Их Сургуулийн Үйлдвэрийн дадлагаа амжилттай хамгаалаад ирсэн.

9. Б.Батдорж нь 2019 онд хугацаанд цэргийн албанд татагдан, цэргийн албаа амжилттай хамгаалж халагдан ирсэн. Одоо Үндэсний аврах бригадад сувлагчаар ажиллаж байгаа.



## Монголын СОС хүүхдийн хотход

Байгууллагын нэр	Монголын СОС хүүхдийн хотход
Байгуулагдсан он	2002 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, 16-р хороо, 16-р хороолол, Улаанхуарангийн гудамж-1
Утасны дугаар	451702
E-mail	Sos.Mongolia@sosmon.mn
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	Үндэсний захирал Ж.Цэрэндаваа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Олон улсын СОС Хүүхдийн Хотход байгууллага нь 73 жилийн турш Хүүхдэд үзүүлэх Халамжийн хувилбарт үйлчилгээний нэг хэлбэр болох Гэр бүлд суурилсан үйлчилгээг дэлхийн сая сая хүүхдүүдэд хүргэн ажилласаар ирсэн.</p> <p>Тус байгууллагын Монгол дахь салбар Монголын СОС Хүүхдийн Хотход нь 2002 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 2500 гаруй хүүхдийг энэхүү үйлчилгээнд хамруулан гэр бүлийн аюулгүй орчинд амьдрах, боловсролтой, нийгэмд биеэ даан амьдрах чадвартай хувь хүн болгон төлөвшүүлэхийн зэрэгцээ мөн хүүхдийг гэр бүлээсээ салах эрсдэлээс урьдчилан сэргийлэн, өрхийг дэмжин ажиллаж байна.</p> <p>Сүүлийн 20 жилийн хугацаанд Монголын СОС Хүүхдийн Хотход нь хүүхэд, залуус, гэр бүлийн өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа өргөжүүлэн, хөгжүүлэн ажилласаар ирлээ.</p> <p>Одоогийн байдлаар манай байгууллага нь 2 СОС Хүүхдийн Хотхон, 2 Залуусын үйлчилгээ, 1 Гэр бүл дэмжих хөтөлбөрөөрөө дамжуулан бидний тусламж, дэмжлэг хэрэгтэй хүүхэд, залуус болон гэр бүлүүдэд үйлчилгээгээ хүргэн ажиллаж байна.</p> <p>СОС Хүүхдийн Хотхонд амьдарч буй хүүхдүүд жирийн гэр бүлийн адил СОС ээжийн хамт амьдардаг бөгөөд цэцэрлэг, сургуульдаа хамрагдахын зэрэгцээгээр Хотхоноос зохион байгуулж буй нэмэлт хичээлийн давтлага /тоо, Монгол хэл г.м/, шатар, даам, дуу, бүжгийн дугуйланд давхар хамрагддаг. Хотхонд амьдарч буй хүүхдүүд нэгэн гэр бүл болон хамтдаа амьдардаг.</p> <p>Залуусын үйлчилгээнд амьдарч буй залуус /охид, хөвгүүд/ Хотхоноос зохион байгуулж буй сургалт, үйл ажиллагаанд давхар хамрагддаг бөгөөд нэмэлтээр ирээдүйд бие даан амьдрах, амьдрах ухаан, чадварт суралцах, нийгэмд биеэ зөв авч явах, харилцааны чадварт суралцах зэрэг нэмэлт сургалт, үйл ажиллагаануудад хамрагддаг.</p> <p>Гэр бүл дэмжих хөтөлбөрт хүүхдүүд өөрсдийн төрсөн аав, ээж, ах дүүсийн хамт хамрагддаг бөгөөд тухайн хөтөлбөрөөс зохион байгуулж буй боловсрол, эрүүл мэнд, сургалт зөвлөгөө, тусламж дэмжлэг зэрэг үйл ажиллагаануудад хамрагддаг. Мөн эцэг эхчүүд нь оёдлын болон мужааны сургалтуудад хамрагдсанаар хүүхдүүддээ болон гэр бүлийн бусад гишүүддээ хувцас хийж өгөх, өөрийн гэр орон, хашаа байшингаа засварлах зэрэг олон зүйлсийг бие даан хийж чаддаг болдог. Энэ нь цаашлаад тухайн гэр бүлийн санхүүгийн нөхцөл байдалд ч мөн эерэгээр нөлөөлдөг бөгөөд ингэснээр хүүхдүүд гэр бүлийн хамт амьдрах боломж бүрддэг.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





### Хөгжлийн хэлхээ

Байгууллагын нэр	Хөгжлийн хэлхээ
Байгуулагдсан он	2006 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, 19-р хороо, Цайзын 49-р гудамж 08 тоот
Утасны дугаар	91193364,91091206
E-mail	Hogjliinhelhee_center@yahoo.com
URL/Facebook	Development Alliance
Төлөөлөгчийн нэр	А.Долгор
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>2006-2009 онд Архины хамааралтай 10 өрх гэр бүл                  2009-2011 онд Хараа хяналтгүй хүүхдүүд тэдний гэр бүл                  2011-2021 онд Эрсдэлт бүлгийн хүүхдүүд тэдний гэр бүлтэй ажиллаж байна.                  Үзүүлдэг үйлчилгээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн ажлын үйлчилгээ</li> <li>• Хүүхэд хөгжүүлэх үйлчилгээ</li> <li>• Нийгэмшүүлэх үйлчилгээ</li> <li>• Сэтгэл зүйн үйлчилгээ</li> <li>• Сэтгэл заслын үйлчилгээ</li> <li>• Хүүхдийн өдрийн үйлчилгээ</li> </ul>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	2009 он Олон улсын хөдөлмөрийн байгууллага 2012 он Канад сан 2013 он Канадын Дүфрэнэ Горьеторийн сан 2020 он БНСУ-ын Койка ОУБ 2021 он Дэлхийн зөн ОУБ
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





### СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛСАН БЯЦХАН ЗӨГИЙН ӨДРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

"БЯЦХАН ЗӨГИЙН" халамжийн өдрийн үйлчилгээ нь 2009 оноос БЗД-ийн 19-р хорооны нутаг дэвсгэрт байрлан АТД, эрсдэлт бүлгийн хүүхдүүдийг орон нутаг, харьяа дүүрэг харгалзахгүйгээр хамруулан ажиллаж байна. Жил бүр 30 гэр бүлийн 70 гаруй хүүхдүүд хамруулж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.



2013 оны 1-р сарын 23-наас эхлэн БЗД-ийн 19-р хорооны нутаг дэвсгэрт орон нутаг, дүүргийн харьяал харгалзахгүйгээр АТД өрх толгойлсон эцэг эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрсдэлт бүлгийн сургуулийн өмнөх насны 1-5 настай хүүхдүүдэд хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулж байна.



Хаяг: Улаанбаатар хот, БЗД, 19-р хороо, Цайз 49 гудамж, 08 тоот  
Холбоо барих: 9119 3364  
У-мэйл: hogliinthee\_center@yahoo.com  
Сошиал хаяг: JOY хүүхдийн өдөр өнжүүлэх халамжийн төв



### ХӨГЖЛИЙН ХЭЛХЭЭ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Манай байгууллага нь 2006 оноос амьдралын түвшин доогуур, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хүнд хөдөлмөр эрхэлдэг, хараа хяналтгүй хүүхдүүд, өрх толгойлсон эцэг болон эхчүүдэд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж ирсэн.

2009 оноос эрсдэлт бүлгийн ЕБС-н болон сургууль завсардсан хүүхдүүдэд зориулсан халамжийн өдрийн үйлчилгээг орон нутаг болон дүүрэг харгалзахгүйгээр хамруулан нийгмийн ажлын болон чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх хөтөлбөрүүдийг санаачлан ажиллаж байна.

2013 оноос сургуулийн өмнөх насны 1-5 насны хүүхдүүдийг нийгмийн ажлын үйлчилгээ болон хүүхэд хамгааллын үйлчилгээнд гэр бүл, халамжийн өдрийн үйлчилгээнд хамруулан өрх толгойлсон эцэг эхчүүдийг хөдөлмөр эрхлэх боломжоор ханган ажилласаар байна.

2018 оноос хойш хүүхэд хамгааллын харуу үйлчилгээ үзүүлэх магадлан илгэмжлэгдсэн байгууллагаар ажиллаж байна.

### "ХӨГЖЛИЙН ХЭЛХЭЭ" НҮТББ-Н ЭРХЭМ ЗОРИЛГО:

Эрсдэлт бүлгийн хүүхдүүдэд хүүхэд хамгааллыг үйлчилгээ үзүүлэх, гэр бүл нь эргэн нэгтгэж, гэр бүлийн халуун дулаан, аюулгүй, энэрэнгүй, хайр халамж дүүрэн гэр бүлд өсөн торних орчин нөхцлийг бүрдүүлэх.

### АЛСЫН ХАРАА:

Эрүүл гэр бүл, боловсролтой амьжиргааг хангах хүмүүнлэг нийгэмшлийг бий болгох.

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

#### 1. Хүүхэд хамгааллын үйлчилгээ:

- Хүүхдийн тэвчшлэг хүнд хөдөлмөр эрхэлдэг, сургууль завсардсан болон хараа хяналтгүй хүүхдүүдийг нийгэмшилэх ЕБС-н сургууль, НТБ-н андуг сургах, МСУТ, эцэдрэлт холбон зуучлах

#### 2. Нийгмийн ажлын үйлчилгээ:

- Хүнд нөхцөлд амьдарч байгаа, эрсдэлт бүлгийн, хүчирхийлэлд өртсөн хүүхэд тэдний гэр бүлийн гишүүдэд нийгмийн ажил, сэтгэл зүйн болон халамжийн үйлчилгээ үзүүлэх,
- Өрхийн амжиргаа доогуур орлогогүй эцэг эхчүүдийг мэргэжил олгох сургалтад сургах, ажлын байранд холбон зуучлах, бичиг баримтгүй иргэдийг бичиг баримтжуулах.

#### 3. Хүүхэд хөгжлийн үйлчилгээ:

- Халамжийн өдөр өнжүүлэхэд 1-16 насны хүүхдүүдийг хамруулах, хичээлээс гадуурх аялал зугаалга, эвний хөтөлбөр, эрүүл мэндийн үйлчилгээ, хувцас, хичээлийн хэрэгслэлээр хангах, дугуйланг хамруулах, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлэх

### ХИЙГДСЭН АЖЛУУД:

2006-2009 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйнүүдэд нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж шаардлагатай үйлчилгээг үзүүлэн арга хэмжээнүүдийг авсан. Мөн нэн ядуу, өрхийн орлогогүй 10 гэр бүлийн өрх толгойлсон эцэг, эхчүүдэд мэргэжил олгох сургалтад хамруулж, ажлын байранд холбон зуучилсан. Улмаар 8 гэр бүлүүд өрхийн тогтмол орлоготой болгон бие даан амьдрахад нь дэмжсэн.

2009-2013 онд хүүхдийн тэвчшлэг хүнд хөдөлмөр эрхлэн хүнд нөхцөлд амьдарч байгаа, хараа хяналтгүй хүүхдүүдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, өдрийн үйлчилгээ, нийгмийн ажлын үйлчилгээг 30 гэр бүлийн 42 хүүхэд үзүүлэн хэвийн амьдралд буцаан гэр бүлд нь эргэн нэгтгэсэн.

2011-2012 онд эмээг бүлгийн, хараа хяналтгүй 10 өрхийн 15 хүүхэд тэдний гэр бүлтэй ажиллаж эцэг эхчүүдийн чадамжийн үнэлгээг гарган боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөө, сургалтад хамруулж ажилтай болгохын тулд тэднийг бэлтгэн ажлын байранд зуучилснаар 10 өрх гэр бүл тогтмол орлоготой болж сургууль завсардсан хүүхдүүд сургуульд бүрэн хамрагдсан. Канад сангийн түслэмжтэйгаар өрөөний тохижуулалт хийснээр хүүхдүүд өдрийн үйлчилгээ авах боломж нэмэгдсэн. Хүүхдийн төлөө үндэсний газар, Нийслэлийн хүүхдийн төлөө газар хамтран ажилласан.

2013 оноос бага насны болон сургуулийн насны хүүхдүүдэд зориулан хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан өдөр өнжүүлэх төвийг ажиллуулж байна. Эцэг эх гэр бүлийн гишүүдийн орлооог нэмэгдүүлэх чиглэлээр сар бүр хөтөлбөр гарган ажиллаж байна. Хамтран ажилласнаар 30% өрхийн тогтмол орлоготой болсон амжилттай ажиллаж байна.



### ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

2006 оноос хойш Дүүргүүдийн засаг даргын тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Цагдаагийн хэлтэс, Хороодууд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Олон улсын байгууллагууд, Айж ахуй нэгж байгууллагууд болон хувь хүмүүстэй хамтран ажиллаж ирсэн.





**Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төв**

Байгууллагын нэр	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төв
Байгуулагдсан он	2009 он
Хаяг	Баянгол дүүрэг,17-р хороо, Амарсанаагийн гудамж-7, Гурван Эрдэнэ Багшийн Дээд Сургууль, 101 тоот
Утасны дугаар	99275022
E-mail	amandakh5022@yahoo.com,nmandah5022@gmail.com
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	Гүйцэтгэх захирал А.Нармандах
Үйл ажиллагааны товч танилцуулга	<ol style="list-style-type: none"> <li>1. Сургуулийн өмнөх боловсролын шинэчлэлийн бодлогын хүрээнд БШУЯ-ны СӨБ-ын хэлтэс, НҮБ хүүхдийн сан, Монгол дахь ЯХИС, БХ-тэй хамтран сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нарт сургалт, гарын авлага боловсруулах, түгээн дэлгэрүүлэх ажлууд одоо үргэлжилж байгаа.</li> <li>2. БШУЯ-ны стратеги бодлого төлөвлөлтийн газрын захиалгаар СӨББ-ын сургалтын орчны MNS6558;2015 стандарт боловсруулж, Үндэсний стандарт хэмжил зүйн газраар батлуулсан, цэцэрлэгүүд мөрдөн ажиллаж байна.</li> <li>3. БМДИ-ийн зөвшөөрөлтэй 2011 оноос эхлэн хүүхдийн цэцэрлэгийн удирдлага, багш, багшийн туслах багш нарыг чадваржуулах сургалт, зөвлөн туслах менторын үйл ажиллагаа явуулж байна.</li> <li>4. 2010 оноос эхлэн Хүүхдийн цэцэрлэгийн туслах багш бэлтгэх сургалтыг 2021 оны 3 сар хүртэл бие даан хичээлүүлж байсан туршлагатай, 2021 оны 6-р сараас Гурван-Эрдэнэ багшийн дээд сургуулийн Хүүхдийн цэцэрлэгийн туслах багш бэлтгэх сургалтыг хариуцан ажиллаж байна.</li> <li>5. НҮБ-ын Хүүхдийн сангийн “Бага насны хүүхдийн цогц хөгжил” төслийн хүрээнд сургагч багшийн гарын авлага, эцэг эхэд зориулсан зөвлөмж ном, цуврал сургалтын модуль боловсруулан Баянхонгор, Өмнөговь, Говь-Алтай, Завхан аймгийн 8 сум, БЗД-ийн 17-р хороог хамруулан эцэг эх, асран хамгаалагч нартай ажиллах сургагч багш бэлтгэх, аймгийн зөвлөх баг бэлтгэх чадваржуулах сургалт, үйл ажиллагааг удирдан ажиллаж байна. Төслийн үргэлжлэх хугацаа 2021 оны 3-р сараас 2022 оны 5 сар хүртэл.</li> </ol>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй

НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилттэй “Бага насны хүүхдийн цогц хөгжил” төслийн сургалтын явц



Туслах багш, цэцэрлэгийн багшийн сургалтын үйл явцын зураг



**Монголын эмэгтэйчүүдийн сан**

Байгууллагын нэр	Монголыг эмэгтэйчүүдийн сан
Байгуулагдсан он	2000 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,6-р хороо,48-р байр,305 тоот
Утасны дугаар	77119991
E-mail	info@mones.org.mn
URL/Facebook	MongolianWomensFund
Төлөөлөгчийн нэр	Гүйцэтгэх захирал Б. Агни
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>МОНЭС нь эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд, орон нутгийн бүлгүүдэд санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэх замаар охид, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлж нийгмийн өөрчлөлтийг бий болгох зорилго бүхий ТББ юм. Өнгөрсөн 20 жил МОНЭС 2.0 сая долларын үнийн дүнтэй, нийт 752 тэтгэлгийг дараах бүлгүүдэд олгожээ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Феминист идэвхтнүүд, хүний эрхийг хамгаалагчид, эмэгтэйчүүд, охидын өөрөө удирдах байгууллагууд, эмэгтэй удирдагчтай нутгийн иргэдийг түшиглэсэн байгууллагууд;</li> <li>• Нийгэмд гадуурхагдсан болон үйлчилгээ хүрдэггүй эмэгтэйчүүд, охид, үүний дотор нэн ядуу, бэлгийн цөөнх, залуу эхчүүд;</li> <li>• Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсөд, үүний дотор бэлгийн хүчирхийлэлд өртсөн охид;</li> <li>• Үндэсний болон орон нутгийн түвшин дэх эмэгтэй удирдагчид, шийдвэр гаргагчид;</li> <li>• Эмэгтэй бизнес эрхлэгч, жижиг бизнес эрхлэгчид;</li> <li>• Байгаль орчны шударга бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөнд автсан хөдөөгийн эмэгтэйчүүд, орон нутгийн иргэд.</li> </ul> <p>Эдгээр тэтгэлгийг хэрэгжүүлэхдээ ядууралд өртсөн, хөдөө алсмагдал газар амьдардаг эмэгтэйчүүд, охидын орлого бий болгох үйл ажиллагаанд санхүүгийн шууд дэмжлэг өгөх, жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах байрны ажиллагааны зардлыг санхүүжүүлэх, уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөнд автсан орон нутгийн иргэдийн эрхийг хамгаалах стратегийн өмгөөлөл хийх, эмэгтэй удирдагчтай иргэний нийгмийн болон нутгийн иргэдийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, ажлын байран дахь дарамт (АББД), үүний дотор бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх бодлогын нөлөөлөл хийх, үндэсний болон орон нутгийн түвшинд хууль тогтоогч, бодлого боловсруулагчидтай ажиллахад дэмжлэг үзүүлж ирэв.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<p>Гадаад эх үүсвэрээс хөрөнгө дайчлах талаар өнгөрсөн 20 жилд ихээхэн амжилттай ажиллалаа. Эмэгтэйчүүдийн олон улсын сан (the Global Fund for Women), MamaCash байгууллагууд бол МОНЭС үүсгэн байгуулагдсан үеэс өглөгийн гараа сунгасан анхны байгууллагууд бөгөөд 2001 онд 57,000 ам долларын дэмжлэг олгож байв. Энэ хугацаанд хоёр талын засгийн газруудын санхүүжүүлэгч байгууллагууд, эмэгтэйчүүдийн сангууд, НҮБ болон Европын холбоо зэрэг олон улсын байгууллагуудын итгэлцлийн сан, дотоодын компаниудаас хөрөнгө босгож санхүүжилтийн эх үүсвэрээ өргөжүүлж байна.</p>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





**Алсын харгаа**  
**Эрхийн зорилго**

Эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах, тэд өөрсдийгөө бүрэн гүйцэд илэрхийлж, нийгмийн оролцогч гол хүчин байж, хүндлэгдэх.

Монголын эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө нөөц, баялаг, мэдлэг, арга ухаан хуримтлуулж, санхүүгийн болон мэдлэг арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

Эмэгтэйчүүдийн өөдрөг тэмүүлэл, гярхай нүд, уян ухаан, нандин арга, хязгааргүй эрч хүч манай нийгмийг шударга, тэгш болгон өөрчилнө гэдэгт **итгэдэг**.

Охид, эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийг багасгахын төлөө **хөрөнгө босгодог**.

Охид, эмэгтэйчүүдийн бүтэцлэн оролцоо, дуу хоолойгоо нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийг зогсоохын төлөө тэдний хамтын ажиллагааг **дэмждэг**.

Нийгмийг өөрчлөхийн төлөө хандив өргөх филантропи үзэл санааг **түгээн дэлгэрүүлж байна**.

**БИД**



**Vision**  
**Mission**

Women enjoy equal rights with men, they are able to fully realize themselves, are a major force in the society and are recognized and appreciated.

To provide financial and technical support for the advancement of status of women in Mongolia through mobilization of funds and resources, knowledge and skills

**believe** that women's high aspirations, unlimited energy, sharp eyes, flexible minds, comprehensive approaches can make a change for better justice and equality in our society

**raise funds** to reduce violations of girls' and women's rights.

**support** collaborations to raise voices of girls and women and reveal violations and omitted issues of women's rights.

**promote** philanthropy culture for social change.

**WE**

**БИД ДАРААХЬ 5 ЧИГЛЭЛЭЭР ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТӨРИЙН БҮС БАЙГУУЛЛАГА, БҮЛГҮҮДэд ТЭГТЭЛЭГ ӨЛГӨЖ БАЙНА.**



**WE DISBURSE GRANTS TO WOMEN'S GROUPS AND ORGANIZATIONS WORKING IN THE FOLLOWING 5 DIRECTIONS.**



## Нийгмийн түншлэлийн сүлжээ

Байгууллагын нэр	Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ
Байгуулагдсан он	2004 он
Хаяг	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, бага тойруу 18/1-10 тоот
Утасны дугаар	329888, 99192169, 99030762
E-mail	nts2019rsc@gmail.com, tsevelmaaenkhtuya@gmail.com
URL/Facebook	Social Partnership network/Нийгмийн Түншлэлийн Сүлжээ/
Төлөөлөгчийн нэр	Ц.Энхтуяа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>“Нийгмийн Түншлэлийн Сүлжээ” (НТС) нь иргэд, бүлэг, хамт олон, орон нутгийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх, орон нутгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилготой нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм. НТС ТББ нь ДаМоСТ –оос нийгмийн эмзэг бүлэгт нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлж, нийгмийн ажилтан бэлтгэх явцад үүсч, орон нутгийн нийгмийн ажилтны хамтын ажиллагаа, түншлэлийн үр дүнд 2004 онд байгуулагдсан. Тус байгууллага нь 2000 гаруй гишүүдтэй, аймаг, нийслэлийн дүүргүүдэд нийт 12 газар салбартай.</p> <p>Хараа хяналтгүй хүүхдүүдийг сургах, хөгжүүлэх, мэргэжилтэй болгох, бага орлоготой айл өрх, иргэдийг чадваржуулах, ядуурлыг бууруулахад хувь нэмрээ оруулах, орон нутагт иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлж байсан ба Хуримтлал Зээлийн 400 орчим бүлгийг байгуулан ажиллуулсан. Үүний үндсэн дээр 200 гаруй бичил болон жижиг бизнес эрхлэгчид чадваржиж, патент, зөвшөөрөлтэй компани , хоршоод байгуулагдсан. Орон нутагт НТС, түүний салбарууд бэхжиж олонд танигдах болсон. НТС нь Данийн Олон Улсын Хөгжлийн Байгууллага (ДАНИДА)-ын болон CISU-гээс санхүүгийн дэмжлэг авч байсан. Дани улс дахь Дани-Монголын Нийгэмлэгтэй үр бүтээлтэй хамтран ажилласаар ирсэн.</p> <p>НТС ТББ нь 12 салбараараа иргэдэд сургалт, зөвлөгөө, ХЗБ-ийг байгуулах, бүлгүүдийг чадваржуулах, олон нийтийн болон нөлөөллийн ажлуудыг хийж байна.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Дани улсын ТББ-тай олон жил хамтарч ажилласан. 2000 онд хараа хяналтгүй хүүхдүүдтэй ажиллаж байхад 10-аад хүүхдийг мэргэжлийн сургалт, курс-д сургахад Японы нэг тусламжийн байгууллагатай хамтран ажиллаж байсан.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Одоогоор байхгүй.







**Монголын эмэгтэйчүүдийн амьдрал төв**

Байгууллагын нэр	Монголын эмэгтэйчүүдийн амьдрал төв
Байгуулагдсан он	2005 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, бага тойруу-1 А. Амарын гудамж 22а-302 тоот
Утасны дугаар	99818199
E-mail	jambaladya500@gmail.com
URL/Facebook	Жамбал Адъяа
Төлөөлөгчийн нэр	Жамбалийн Адъяа
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Өрх толгойлсон , өрхийн орлого бага, олон хүүхэдтэй, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг дэмжих, амьдрах ухаанд сургах, биеийн тамир спорт,соёл урлагт оролцуулах,сургалт, уулзалт зохион байгуулах, төсөл хөтөлбөрт хамрагдах, ижил зорилготой байгууллага, хүмүүстэй хамтран ажиллаж нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлнэ. 2005 онд байгуулагдсан.</p> <p>Алсын хараа: Эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг өсгөх замаар тэднийг өөрийн гэсэн орлоготой , эрх мэдэлтэй, эв нэгдэлтэй болоход нөлөөлнө. Хамтын ажиллагаа, бүлэг, баг бий болгох замаар эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг бэхжүүлэх.</p> <p>Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хүний эрхийн асуудлаар судалгаа хийх, дүгнэлт гаргах, асуудал боловсруулж шийдвэрлүүлэх. Бидний уриа: Би манлайлагч эмэгтэй, Бид чадна Бидэнтэй хамтран ажилладаг байгууллагууд: Монголын Эмэгтэйчүүдийн Сан,Монголын ЭмэгтэйчүүдийнТББ-уудын үндэсний сүлжээ /Монфемнет/, Адра сан, Хүний эрх хөгжил төв, Хүний эрхийн форм, Монголын Эмэгтэйчүүдийн холбоо, Дархан уул хотод нэг хүний бие даасан “Уран шаглаа” бүлэг , улмаар УБ хотын Баянгол, Сүхбаатар,Баян зүрх,ХанУул дүүргүүдийн Энэрэл,Найман од, Ундарга, Хөвсгөл аймагт “Хөвсгөл дэвжих”,Баянхонгор аймагт “Мандал хайрхан” бүлгүүд, Хилчин заяа, Суврага хайрханы баялаг НҮТББайгууллагуудтай хамтран ажиллаж ирсэн.</p> <p>Бид өрх толгойлсон эмэгтэйчүүддээ сургалт явуулж мөнгөн хөрөнгийн бүлэг байгуулан ажиллуулж сургалт, уулзалт,аялалд орон нутгуудаар зуны сургалтанд хамруулж туршлага солилцуулсан. Малчин эмэгтэйчүүдийн ажлын арга барил нь мал төллөлтөө бүрэн авч маллах, цагаан идээ боловсруулах, гар урлал хийж борлуулалт хийх, Хот, орон нутгийн эмэгтэйчүүд нь спорт, уулын аялал, бүжиг дэглэлт, уран зураг, фото зургийн тэмцээнүүдэд оролцож улмаар жимс, хүнсний ногоо тарьж амьдрал ахуйдаа хэрэглэж байна. Судалгаанд хамрагдсан өрх толгойлсон эмэгтэйчүүд, хүүхдүүдэд цүнх, ном, дэвтэр, үзэг бал, хувцас тараан өгч тусалсан. Бид олон орны эмэгтэйчүүдтэй туршлага солилцон тэмцээн уралдаан зохион байгуулж хамтран ажиллана.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



## Бадамлянхуа хүүхдийн төв

Байгууллагын нэр	Бадамлянхуа хүүхдийн төв
Байгуулагдсан он	1995 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, 20-р хороо, Гачуурт Бага ам 2-32тоот
Утасны дугаар	99789750 99132100
E-mail	info@lotuschild.org
URL/Facebook	Lotus children center mongolia
Төлөөлөгчийн нэр	Б.Болормаа
Үйл ажиллагааны товч танилцуулга	Бадамлянхуа хүүхдийн асрамжийн төв нь 1995 оноос хойш хүүхдийн асрамж халамжийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн бус төрийн бус байгууллага юм. Одоогийн байдлаар 2-18 насны нийт 69 хүүхэд амьдардаг. Хандив тусламжаар санхүүждэг.
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Олон улсын байгууллага хамтын ажиллагаа байхгүй. Недарланд, Австрали, Англи улсаас тогтмол тусалдаг хувь хүмүүс байдаг.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	ЖАЙКА-тай хамтарсан төсөл хөтөлбөр байхгүй.





## Сайн ирээдүйн төлөө

Байгууллагын нэр	Сайн ирээдүйн төлөө
Байгуулагдсан он	2008 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, 5-р хороо, монелийн 26 гудамж 576 тоот
Утасны дугаар	91641006, 99778695, 96644284
E-mail	Oyunaa1957@gmail.com, Ssuk358@gmail.com
URL/Facebook	
Төлөөлөгчийн нэр	Ж.Оюунбилэг
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Манай байгууллага нь 3 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.</p> <ol style="list-style-type: none"><li>1. Хүүхэд хөгжлийн төв: энэ төвд 2-7 насны 25 хүүхэд хамрагдаж байгаам бөгөөд, өрх толгойлсон эхчүүдийн хүүхэд болон нийгмийн эмзэг давхаргын хүүхдүүд хамрагддаг</li><li>2. Өрх толгойлсон ээжүүдийг дэмжих үйлчилгээ: залуу өрх толгойлсон ээжүүдийг үнэ төлбөргүй байраар хангаж, ажлын байранд холбон зуучилж, амьдрах орон гэртэй болж бие даан амьдрах боломж руу чигрлүүлж ажилладаг.</li><li>3. Өдөр өнжүүлэх. Хараа хяналтгүй хүүхдүүд болон, архины хамраалтай эцэг эхчүүдийн хүүхдүүд, амжиргааны түвшинээс догуур орлоготой өрхийн хүүхдүүд хамрагддаг. Өдөр өнжүүлэх дээрээ ирээд халуун хоол идэх, хичээлээ давтах, халуун усанд орох, тав тухтай орчинд байх, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ авах.</li></ol>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Байхгүй
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



**Монголын хүүхдийн эрхийн үндэсний төв**

Байгууллагын нэр	Монголын хүүхдийн эрхийн үндэсний төв
Байгуулагдсан он	1997 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Монголын Хүүхдийн ордон, 2 тоот
Утасны дугаар	328926, 99010297
E-mail	tzeveen@yahoo.com, mnccr01@gmail.com
URL/Facebook	Монголын Хүүхдийн Эрхийн Үндэсний Төв/MNCCR
Төлөөлөгчийн нэр	П.Цэвээн, Тэргүүн
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Манай байгууллага Хүүхдийн эрх, хүүхдийг хүчирхийллээс, урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр бодлого боловсруулах хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагчдад нөлөөлөх, шийдвэрийн хэрэгжилтийг үзлэх, эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийн эрхийг хамгаалах үйлчилгээ үзүүлдэг.</p> <p>Хүүхдийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын хууль, Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг боловсруулж, баталгаажуулахад төр болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.</p> <p>Хүүхдийн эрхийг хамгаалж хараа хяналтгүй хүүхдүүдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ бий болгох, хүүхдүүдийг нийгэмшүүлэх: 1997-2010 оны хооронд нийт 1014 гэр бүлд тусламж, үйлчилгээ үзүүлж, 3 өрхийг гэртэй болгоход дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж ирсэн.</p> <p>Халамж асрамжийн төвүүдийн мөрдөх стандартыг санаачлан боловсруулах ажлыг баталгаажуулснаар Халамж асрамжийн төвд амьдарч байгаа 800 гаруй хүүхдэд стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлэхэд оролцож ажилласан.</p> <p>Морь унаач хүүхдүүдийг өвөл уралдуулахыг зогсоох шийдвэр гаргуулахад нөлөөлж, нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд хандаж, бүх шатны шүүхээр Хууль бус үйлдэл гэдгийг тогтоолгож 14000 унаач хүүхдийн эрхийг хамгаалсан.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• 2001 он Японы “VIVA-28”, “XXI зуун” зэрэг олон улсын байгууллага</li> <li>• 2002-2004 он Японы Экологийн Сан</li> <li>• 2005 он Японы ЭСЯ-ны “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд хуучин ширээ сандлыг дахин ашиглах төслийг хэрэгжүүлж, Япон улсын Сайгама мужийн футо дунд сургуульд хэрэглэгдэж байсан 1070 ш ширээ, сандлыг хот хөдөөгийн ЕБС, цэцэрлэг, дотуур байр, сургалтын төв зэрэг 15 байгууллагад үнэгүй тараасан.</li> </ul>
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй





## Дэлхийн зөн Монгол ОУБ

Байгууллагын нэр	Дэлхийн зөн Монгол ОУБ
Байгуулагдсан он	1995 он
Хаяг	Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Соман Плаза, 4-р давхар 15160, шуудангийн хайрцаг 705
Утасны дугаар	70155323
E-mail	mongolia@wvi.org
URL/Facebook	@wordvisionmongolia www.worldvision.mn
Төлөөлөгчийн нэр	Болорцэцэг Болд (Үндэсний захирал)
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>Хүүхдийн сайн сайхан байдлыг хангахын төлөө ажиллаж буй Дэлхийн зөн Монгол ОУБ-ын 2021 онд Монгол Улсад хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн мэдээллийг байгууллагын стратегийн зорилтуудын хүрээнд Монгол улсын 19 аймаг, нийслэл Улаанбаатар хотын 6 дүүрэгт 17 Орон нутгийн хөгжлийн буюу урт хугацааны 12 тусгай төсөл хэрэгжүүлсэн. Дээрх төсөл хөтөлбөрүүдийг байгууллагын 270 гаруй ажилтан, орон нутгийн иргэд, сайн дурынхан, төрийн ба төрийн бус түншлэгч байгууллагууд хамтран хэрэгжүүлсний үр дүнд 259000 хүүхэд, 200000 гаруй насанд хүрэгчдэд төслийн үр шим шууд хүрсэн билээ. Зорилтот Өрхийн Амьжиргааг Дэмжих Хөтөлбөр:Зорилтот бүлгийн өрхийн амьжиргааг сайжруулах; -Зорилтот бүлгийн өрхийн орлого, ажил эрхлэлт, бичил бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх; Иргэдийн гамшгийн эрсдлийг даван туулах чадавхийг дээшлүүлэх зорилготой ба 2021 онд 53,027 охид, 50,871 хөвгүүд 208 хуримтлалын бүлгээр 5,563 хүн хөтөлбөрийн үр шим хүртсэн байна. Хүүхдийн Оролцоо, Хамгааллыг Дэмжих Хөтөлбөр: Хүүхэд, гэр бүл, орон нутгийг чадваржуулж, хүүхэд хамгааллын механизмыг сайжруулах замаар охид хөвгүүдийг хүчирхийллээс хамгаална. 2021 онд хөтөлбөрийн үр шим хүртсэн хүний тоо: 41,813 эцэг эх, асран хамгаалагч 500 орчим өрхөөр айлчлагч 4,500 өрх 19,499 охид 16,787 хөвгүүд хөтөлбөрийн үр шим хүртсэн байна. Иргэд олон нийт, хүүхэд залуучуудын нийгмийн идэвх оролцоог сайжруулах хөтөлбөр-Иргэдийг чадавхижуулж орон нутгийн хөгжлийн үйл ажиллагаанд татан оролцуулах; Хүүхдийн төлөөх үндэсний хэмжээнд төр, төрийн бус, хувийн хэвшил, иргэдийн түншлэлийг сайжруулах</p> <p>Грант төслүүд: Грант санхүүжилттэй 8 төсөл-2 нь хүүхэд хамгааллын үйлчилгээг бэхжүүлэх, 6 нь өрхийн аж байдлыг сайжруулахад чиглэж байна.Хамтран ажиллаж буй ИНБ-ын тоо - 127 Грант төсөл хэрэгжиж буй сум, дүүргийн тоо 28, 2021 онд 13790 насанд хүрэгч, 8633 охид, 10551 хөвгүүд грант төслүүдэд хамрагдан үр шим хүртсэн байна.2021 онд 1,553 монгол ивээн тэтгэгч 1,949 хүүхдийн амьдралд баяр хөөр бэлэглэсэн байна.</p> <p>Fruga Төсөл-Үерийн байгууламжийн зураг төслийг боловсруулах, барихад нийслэлийн Засаг захиргаа, түүний харьяа газар, дүүргүүдтэй нягт хамтран Үерийн хамгаалалтын дэд бүтцийн бүтээн байгуулалтын зураглалд газар нь орсон айл өрхүүдтэй анхан шатны бүлгүүдээр дамжуулан хэлэлцээр хийх нь үйл явцыг хөнгөвчилж, тэдний эсэргүүцлийг бууруулдаг. Коронавируст Халдвараас Хамгаалах Чиглэлээр -Нийт 1.3 сая америк долларыг доорх чиглэлээр зарцуулсан байна.Эрүүл ахуйн иж бүрдэл – 2549 Эмнэлгийн ажилтны хамгаалах хэрэгсэл – 511 Эмнэлгийн байгууллагын иж бүрдэл – 1040 Эмнэлгийн тоног хэрэгсэл – 174 Телевиз радиогоор нэвтэрсэн зөвлөмж - 398,288 хүн Бэлэн мөнгөний тусламж 827,558 ам.доллар Хүүхдийн боловсролын дэмжлэг 14,672 хүүхэд</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Дэлхийн Зөн Япон Дэмжигч оффис
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Байхгүй



## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:



**ГҮНЖ ТӨВ**

Байгууллагын нэр	Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах “ГҮНЖ” төв
Байгуулагдсан он	2003 он
Хаяг	Сүхбаатар дүүрэг, 9-р хороо, Их тойруу-70, Хүдэрмөнх оффис 503 тоот
Утасны дугаар	70105105, 96110110
E-mail	Info.princesscenter@gmail.com
URL/Facebook	www.facebook.com/princesscenter
Төлөөлөгчийн нэр	Э. Эрдэнэцэцэг, Гүйцэтгэх захирал
Үйл ажиллагааны товч танилцуулга	<p>ГҮНЖ” төв нь 2003 онд байгуулагдсан, нийгэмд үйлчилдэг, ашгийн төлөө бус, иргэний нийгмийн байгууллага юм.</p> <p>Бид “Охидод ээлтэй нийгмийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах”-ыг хэтийн зорилгоо болгон ажилладаг бөгөөд эрх нь зөрчигдсөн охид, эмэгтэйчүүдийг НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ замаар чадваржуулах, тэдний эрхийг ноцтойгоор зөрчиж буй асуудлуудын талаар ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, улмаар охид-залуу эмэгтэйчүүдэд ээлтэй орчныг бий болгохын тулд БОДЛОГОД НӨЛӨӨЛӨХ чиглэлээр ажилладаг.</p> <p>Манай байгууллага нь хүүхэд төрүүлсэн өсвөр насны охидын эрхийн чиглэлээр ажилладаг цорын ганц байгууллага бөгөөд өнгөрсөн хугацаанд давхардсан тоогоор 900 орчим залуу ээжүүд болон 120 гаруй бэлгийн хүчирхийллийн даван туулагч охидод мэргэжлийн болон урт хугацааны нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж, зөрчигдсэн эрхийг нь хамгаалаад байна. Байгууллагынхаа хүний эрхийн мэдлэгтэй феминист “Охидын эрхийн клуб” болон өсвөр насны эхчүүдийг нэгтгэсэн “ЗАЛУУ ЭХЧҮҮДИЙН КЛУБ”, жөндөрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох зорилготой “ХҮЧИРХЭГ ХӨВГҮҮД КЛУБ”-ыг тус тус ажиллуулдаг ба тэдний идэвхитэй оролцоогоор дамжуулан охид, эмэгтэйчүүдийн эрхийг ноцтойгоор зөрчиж буй нийгмийн асуудлуудын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх олон талт үйл ажиллагаануудыг тогтмол явуулдаг. Түүнчлэн залуу эхчүүдийн нийгмийн идэвхи, санаачлага, оролцоог нэмэгдүүлэх замаар тэднийг манлайлагч болгон бэлтгэх зорилгоор “ЗАЛУУ ЭХЧҮҮДИЙН МАНЛАЙЛЛЫН ХӨТӨЛБӨР”-ыг 2012 оноос эхлэн жил бүр тогтмол хэрэгжүүлж байна.</p> <p>Охид, эмэгтэйчүүдийн эрхийг зөрчиж буй асуудлууд (бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэл, хүсээгүй жирэмслэлт гэх мэт)-ыг УРЛАГ-аар дамжуулан олон нийтэд хүргэх, ойлголт өгөх, нийгэмд айдас төрүүлэхгүйгээр тэдний анхаарлыг дээрх асуудлуудад хандуулах, улмаар оролцоог нь нэмэгдүүлэх зорилгоор үндэсний хэмжээний кампанит ажлуудыг зохион байгуулдаг.</p>
Япон болон олон улсын хамтын ажиллагаа	Тайван улсын The Garden of Hope Сантай 2010 оноос хойш хамтран азийн охидын эрхийн сүлжээг бий болгоход хамтран ажиллаж байна.
ЖАЙКА-тай хамтарсан төсөл, хөтөлбөр	Хамтарсан төсөл, үйл ажиллагаа байхгүй.





2020 оны “ASIAN GIRLS POWER CAMP”  
Монгол улсын төлөөлөгч охид



2021 оны “9<sup>th</sup> ASIAN GIRLS AMBASSADOR”  
М.Нандинчимэг



2021 оны “ОХИДЫН МАНЛАЙЛЛЫН ХӨТӨЛБӨР”-ийн  
төгсөгчид



ГҮНЖ төвийн дэргэдэх нийгэмд ээлтэй бизнес  
“BABY BOX MONGOLIA”